

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

---



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

---

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

---

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРОО

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

|                                   |        |
|-----------------------------------|--------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга   | 1      |
| Хуралдааны товч тэмдэглэл:        | 2 – 3  |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 4 – 40 |

|                                                      |        |
|------------------------------------------------------|--------|
| 1. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал | 4 – 40 |
|------------------------------------------------------|--------|

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 12-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 58 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: С.Амарсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Л.Гантөмөр, Ц.Туваан, О.Цогтгэрэл;  
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Доржханд.*

***Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр, Хуулийн газрын дарга Ж.Мөнхболд нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Баярбаатар, Н.Номтойбаяр, Э.Болормаа, Б.Пүрэвдорж, Ж.Баярмаа, Ж.Золжаргал, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Сандаг-Очир, О.Номинчимэг, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, Э.Болормаа, О.Алтангэрэл, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах тухай саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 3

Бүгд: 19

84.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 89.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 24 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
11 цаг 58 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Дашзэгвийн Амарбаясгалан гишүүн ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн байна, Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирсэн байна, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн байна, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн, Батын Батбаатар гишүүн ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 06 сарын 12-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудлаар тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно гэсэн байгаа.

Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйл Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл журмын 2-т Ерөнхий сайдыг огцруулах, шинээр томилох, чөлөөлөх болон Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай

асуудлыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 6 дахь заалт, 43 дугаар зүйл, 44 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд 99.1.Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулж, эсхүл огцорсонд тооцсон бол шинэ Ерөнхий сайдыг томилох асуудлыг энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

Гишүүд чимээгүй байгаарай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйл.

24.1.Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулснаас хойш Төрийн байгуулалтын байнгын хороо ажлын 3 өдрийн дотор хуралдаанаар хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

24.2.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчдээс асуулт асууж үг хэлж болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

А.Үйлстөгөлдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Ж.Мөнхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн газрын дарга.

Ийм хоёр хүн хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр танилцуулна. 4 номерын микрофон.

**А.Үйлстөгөлдөр:** Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд олонх суудал авсан Монгол Ардын намаас Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэн, саналыг 06 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид ирүүлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хуралд олонх суудал авсан нам эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна гэж заасны дагуу Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг танилцуулж байна.

Гомбожавын Занданшатар нь 1970 онд Баянхонгор аймгийн Баацагаан суманд төрсөн. Эхнэр 4 хүүхэдтэй.

1987 онд Улаанбаатар хотын 10 жилийн 77 дугаар дунд сургууль,  
1987-1992 онд Оросын Холбооны Улсын Эрхүүгийн Улс, ардын аж ахуйн дээд сургуульд суралцаж, санхүү, эдийн засагч мэргэжил эзэмшсэн. Эдийн засгийн ухааны магистрын зэрэгтэй.

Гомбожавын Занданшатар нь ажлын гараагаа Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн багшаар эхлүүлж,

1995-1998 онд Хөдөө аж ахуйн банкинд эдийн засагч, хэлтэс, газрын захирал,

1998-2000 онд Монголбанкны Сургалтын төвийн менежер, Хөдөө аж ахуйн банкинд Монголбанкны бүрэн эрхт төлөөлөгч,

2000-2003 онд ХААН банкны дэд захирал,  
2003-2004 онд Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд,  
2005-2010 онд Монгол Ардын намын дэргэдэх Монголын ардчилсан социалист залуучуудын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, дэд Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч,

2004-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн,  
2009-2012 онд Монгол Улсын Гадаад харилцааны сайд,  
2012-2013 онд Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн дарга,  
2013-2015 онд Америкийн Нэгдсэн Улсын Стэнфордын их сургуулийн Хөгжил, ардчилал, хуулийн засаглалын хүрээлэнд судлаач,

2016-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн,  
2017-2019 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга,

2019-2024 онд Монгол Улсын Их Хурлын дарга,  
2024 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байна.

Гомбожавын Занданшатар нь 1992 оноос хойш эрдэм шинжилгээ, судалгаа, эдийн засаг, гадаад харилцааны чиглэлээр болон төрийн хууль

тогтоох болон гүйцэтгэх засаглалын түвшинд ажилласан төрийн албаны туршлагатай, иргэд, олон нийтийн итгэл, улс төрийн манлайлал, бодлогын тогтвортой байдлыг хангах чадвартай хэмээн үзэж Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулахаар санал болгож байна.

Иймд Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэхийг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгье.

Асуулт асуух. Асуулт, үг тусдаа. Б.Батбаатар гишүүнээр. Н.Номтойбаяр гишүүнийг нэмье. Б.Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

С.Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Монгол Улсын Ерөнхий сайдаар нэр дэвшигдэж орж ирж байгаа Гомбожавын Занданшатарыг дэмжиж байгаа. Юуны өмнө, одоо үүнийг илэрхийлье.

Хоёр их тодорхой асуулт байна.

Одоо ингээд Ерөнхий сайдаар томилогдсон тохиолдолд эхний хийх ажил Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудал байгаа. Нийгмээс янз янзын шүүмжлэл ч байх шиг байна. Яах вэ, нийгэм бол яаж ч шүүмжилж болно.

Нөгөөтээгүүр бодит өнгөрсөн хугацааны бидэнд тулгамдсан, эсвэл туулсан бусад туршлагууд ч байгаа байх. Тулгамдсан асуудал. Үүнтэй уялдсан байдлаар, өнөөгийн цаг үетэй уялдсан байдлаар ч гэдэг юм уу Засгийн газрын бүтцийг ер нь та яаж харж байгаа вэ?

Засгийн газрын бүтэц чинь өнөөгийнх шигээ байх уу, эсвэл үүнийгээ харьцангуй цөөн яамтай, цөөн сайдтай байхаар бодож байна уу? Үндэсний хороотой холбоотой асуудал дээр та ямар төсөөлөлтэй байгаа гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт, бүрэлдэхүүнтэй холбоотойгоор бүрэлдэхүүний тухайд сайд нар дээр та ямар зарчмыг, ямар шалгуурыг чухалчилж байгаа вэ гэсэн асуулт байна.

Хоёр дахь гол асуулт. Төрийн албаны шинэчлэлийг бид өнгөрсөн хугацаанд 4 үе шаттайгаар хийсэн. Төрийн албаны шинэчлэлийн сүүлийн

шинэчлэлийн үе шатан дээр Та өөрөө манлайлж ажилласан. Тухайн үед та Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байсан. 2017 онд батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Та манлайлж ажиллаж байсан.

Одоо төрийн албаны дараагийн тодорхой шинэчлэлүүд, магадгүй тодорхой асуудлыг даван туулах шинэ хуулийн өөрчлөлтүүд хийгдэх ёстой гэсэн судлаачдын байр суурь ч байна, Төрийн албаны өөрсдийнх нь байр суурь байна, нийгмийн байр суурь байна, улс төрийн байр суурь байгаа юм.

Үүнтэй уялдсан байдлаар таны хувьд төрийн албаны шинэчлэлийг цааш нь ямар чиглэлээр үргэлжлүүлэх ёстой вэ гэж бодож байна гэсэн ийм хоёр асуулт байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Ерөнхий сайдад санал болгосон Г.Занданшатар дарга хариулна. 5 номерын микрофон.

**Г.Занданшатар:** Юуны өмнө Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье.

С.Зулпхар гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт, төрийн алба цомхон чадварлаг байх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, энэ чиглэлээрээ төрийн албаны шинэчлэлийг бүхэлд нь хэрэгжүүлэх ийм зорилт тавьж ажиллах ёстой гэж үзэж байгаа.

Төрийн албан хаагчдын тооны өсөлт, үйлчилгээний салбар, төрийн тусгай албаны нийгмийн баталгаа, хангамжийг хангах асуудалтай зэрэгцээд төрийн алба, ер нь бүхэлд нь нэлээн тийм үр ашгийн менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Тийм учраас илүү цомхон, чадварлаг бүтцээр ажиллах ийм чиглэлийг барьж ажиллах болно.

Гэхдээ энэ нь одоогийн улс төрийн болон нийгэм, эдийн засгийн зорилт, чиглэл, хандлагатайгаа нийцэж ажиллах ёстой гэж бодож байна.

Төрийн албаны тухай хуулийг 2017 онд Улсын Их Хурлаар баталсан. Төрийн албаны чиглэлээр хийх засаглалын шинэчлэл төрийн албатайгаа уялдах ёстой гэж байгаа. **GOVERNANCE REFORM** буюу **ЗАСАГЛАЛЫН РЕФОРМ** бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, төрийн албаны хуулийн шинэ орчин нөхцөлтэйгөө энэ авлигатай тэмцэх, энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, төрийн албаны нийтлэг тогтолцоог сайжруулахтайгаа уялдсан ийм цогц засаглал GOVERNANCE REFORM-ыг хэрэгжүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулах.

Хамгийн гол нь “хариуцлагатай”, “үр ашигтай”, “чадварлаг” төрийн албыг бүрдүүлэхэд цаашдын өөрчлөлт, шинэчлэлт гүнзгийрч хэрэгжих ёстой. Энэ чиглэлээр С.Зулпхар гишүүнтэй хамтарч ажиллаж, энэ чиглэлээр Удирдлагын академи, ер нь их сургуульд судалгааны чиглэлээр хамтарч ажиллаж байсан учраас энэ чиглэлээр санал бодлоо илэрхийлж, хамтарч ажиллана гэдэгт итгэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэгдүгээр асуултад хариулт авъя гэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийг өргөн барих үеэрээ миний саяын хэлсэн нийтлэг зарчмын хүрээнд Бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийг хэлэлцүүлэхдээ дэлгэрэнгүй танилцуулж ярилцах болно. Томилогдоод илүү асуудлыг нарийвчлан судлаад гэсэн агуулгаар.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Баярбаатар гишүүн асуулт асууна.

**Б.Баярбаатар:** Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Г.Занданшатар даргад амжилт хүсье. Дэмжиж байгаа. Хэд хэдэн гол асуудал байгаа.

Нэгдүгээрт, эдийн засаг хүндэрч байна гэдэг зүйл нэлээдгүй яригдаж байгаа. Тэгээд бид яг эдийн засгаа аваад үзэх юм бол “ухдаг буюу уул уурхай”, “ургуулдаг буюу хөдөө аж ахуй” гэсэн хоёр зүйл дээр л ер нь дийлэнх нь төвлөрч байгаа.

Уул уурхай нь бас нэг үнэ нь хэлбэлзсэн ч гэсэн бас нэг гайгүй байдаг. Хөдөө аж ахуй, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, газар тариалангийн асуудал жоохон амаргүй байгаа. Энэ салбар.

Тэгэхээр энэ дээр нэлээн бодлого гаргаж ажиллаарай гэж би хүсмээр байна.

Хоёрт, ирэх жилийг чинь “БОЛОВСРОЛЫН ЖИЛ” болгоод зарласан. Боловсролыг дэмжих жил. Тэгээд энэ боловсрол, эрүүл мэнд гэсэн хоёр зүйл дээрээ нэлээн нийтлэг салбар. Тэгэхдээ энэ дээр нэлээдгүй гүйцэтгэх засаглалын бодлого зайлшгүй шаардлагатай байгаа.

Төрийн алба бол сая С.Зулпхар гишүүн ярилаа. Үүнээс гадна асуудал нь өөрөө энэ төрийн өмчит компаниудын асуудал. Хамгийн данхайлгаж байгаа зүйл чинь энэ төрийн өмч дээрээ байгаад байгаа юм. Мэдээж төрийн алба тодорхой түвшнээс данхайсан. Тэгэхдээ илүү хялбар данхайчихсан нь энэ төрийн өмчид байгаа юм.

Тэгээд үүнийг яаж бид цомхон болгох вэ, бүтээмжийг нь дээшлүүлэх вэ гэдэг дээр эдийн засаг талаасаа Та өөрөө нэлээн шийдвэр гаргах байх.

Дараагийн нэг зүйл нь энэ Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль дээр. Өнгөрсөн Засгийн газрын бүрэлдэхүүн хуулийнхаа 15 хувьд хүрээгүй юм. 13.4 хувь эмэгтэйчүүдийн төлөөлөл байсан юм.

Тэгэхээр одоо энэ дараагийн бүтэц, бүрэлдэхүүн дээр Та энэ Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг мөрдүүлж, 15-аас нь болж өгвөл дээш нь 20 хувь руу дөхүүлэх тал дээр анхаараарай гэдгийг би танд захъя.

Тэгээд Засгийн газар цаашдаа тогтвортой байх ёстой. Тогтвортой байхын тулд маш сайн бүтээмжтэй ажиллах ёстой. Улс төрийн зөвшилцлийг шат шатандаа бид ярилцдаг байх ёстой. Парламент нь өөрөө Засгийн газраа хянадагтай адилхан бас хамгаалдаг, дэмждэг байх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Өнөөдөр 126 гишүүнтэй парламент энэ байр суурийг давхар хадгалаад явна. Хий хоосон улс төржилтийг хойш нь тавьж байж л хэдүүлээ зөвшилцөлд хүрнэ л гэж харж байгаа.

Мега төслүүдээ дахин шигших байх гэсэн ийм асуудал байгаа. Яг голлож байгаа эрчим хүч дээрээ л бид ер нь тулах болов уу даа. Эрчим хүчгүйгээр бусад нь явах ямар ч үндэслэл байхгүй юм билээ. Баярлалаа.

Би ер нь амжилт хүсье дээ. Санал хэлчихлээ дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэлж үү.

Б.Батбаатар гишүүн асуултаа асууна.

**Б.Батбаатар:** Аливаа ардчилсан улс оронд туйлын чухал процесс бол эрх мэдэл нэгээс нөгөөд шилжихдээ хүндрэлгүй, хурдтай, богино хугацаанд явж өнгөрөх нь туйлын чухал байдаг.

Тэр үүднээсээ энэ процесс нь сааталгүй явж байвал тухайн улс оронд улс төр, эдийн засаг, засаглалын хямрал үүсдэггүй ийм зүйл байдаг.

Тэгэхээр нэг зүйлийг хэлээд, нэг асуулт асууя.

Монгол Улсын Үндсэн хуулиар Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрх өнөөдрийн Улсын Их Хурал дотор ганцхан намд л хадгалагдаж байгаа. Монгол Ардын намд. Өөр бусад улс төрийн намууд, эвслүүд ямар нэг байдлаар Ерөнхий сайдад санал гаргах, Засгийн газрын бүтэц дээр санал гаргах боломж байхгүй.

Ерөнхий сайдаар Ардын нам нэр дэвшүүлж, Ардын намаас нэр дэвшүүлж орж ирж байгаа Г.Занданшатар дарга нэр дэвшигч маань үе үеийн Засгийн газрууд хууль тогтоомжоор Монгол Улсын Засгийн газар гэдэг боловч Ерөнхий

сайдууд нь Засгийн газрууддаа өөрсдөө нэршил олж өгдөг. Нэг ёсондоо үндсэн зорилгоо тодорхойлж байна гэсэн үг.

“Шинэчлэлийн Засгийн газар, “Хөгжлийн Засгийн газар”, “Шинэ сэргэлтийн” ч гэдэг юм уу. Ингээд Засгийн газрууд өөртөө нэр өгдөг.

Тэгэхээр би Ерөнхий сайдаар нэр дэвшиж байгаа танаас танай Засгийн газар бүрэлдэхдээ ямар шийдлийг санал болгосон, ямар нэршилтэй Засгийн газар байх юм бэ? Тэр агуулгыг боломжтой тодруулж хэлж өгнө үү гэж хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэр дэвшигч Г.Занданшатар дарга хариулъя. 5 номерын микрофон.

**Г.Занданшатар:** Батын Батбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэгээд ямар нэршилтэй Засгийн газар байх вэ гэж. Энэ бол Монгол Улсын Засгийн газар байх нь ойлгомжтой. “Муур хар юм уу, цагаан байх нь гол биш хамгийн гол нь хулгана барьдаг байх ёстой” гэсэн нэг үг байдаг.

Түүн шиг ямар нэршилтэй байх гэхээсээ илүү ард түмнийхээ аж амьдралд бодитой үр өгөөжийг нь өгсөн, ард иргэдтэйгээ ойрхон, ард түмэндээ ээлтэй ийм л Засгийн газар ажиллаж, эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг ард түмэндээ хүргэсэн, тулгараад байгаа хүндрэл, бэрхшээлийг даван туулахад чиглэгдсэн ийм л Засгийн газар байж, ардчилсан Засгийн газар байх ёстой гэсэн ийм л бодолтой байна.

Мэдээж бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль батлагдаад, тэгээд сайд нараа томилоод, анхны Засгийн газрын хуралдаанаа хийгээд, ямар нэршил, ямар чиглэл байх вэ. Тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлоод, тэр талаар Улсын Их Хуралд танилцуулах үедээ энэ талаар дэлгэрэнгүй бодлогоо танилцуулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Номтойбаяр гишүүн асуулт асууна.

**Н.Номтойбаяр:** Өдрийн мэнд хүргэе.

Улс төрийн хувьд хагаралтай. Тэгээд эдийн засаг, санхүүгийн хувьд маш том хямралтай энэ үед Засгийн газрын тэргүүнээр горилогч нэг бол үнэхээр нэг албан тушаал эрх мэдэлд дуртай нэгэн байж болох.

Нөгөө нь, улс төрчийн хувьд энэ хүнд хэцүү цагийг сонгоод ханцуй шамлаад хүндрэл бэрхшээлүүдийг даван туулъя.

Нэг ийм хоёр зааг дээр л хүн өнөөгийн улс төр, эдийн засагт үүссэн хагарал хямралтай үед сонголт хийх байх.

Тэгээд би таныг “ханцуй шамлаад үзье” гэдэг талдаа байгаа болов уу гэж итгэж байгаа. Хувь хүнийх нь хувьд ч мэдэх юм. Олон жил ч хамтраад ажиллаж байсан.

Надад гурван асуулт байна. Өнгөрсөн өдрүүдэд хэвлэлд би гурван зүйлийг хэлсэн.

- Таалагдахгүй байна,
- Эргэлзээтэй байна,
- Итгэл төрөхгүй байна гээд.

Би яагаад энэ гурван үг сонгож хэлэх болсон шалтгаанаа асуулт болгож тайлбарлая.

“Таалагдахгүй” байгаа нь юу вэ гэхээр Монгол төрийн Ерөнхий сайдыг сонгох анхан шатын сонгууль Ардын намын Бага хурал дээр болсон. Удирдах зөвлөлд ямар ч өрсөлдөөнгүйгээр нэг хүн орж ирсэн. Бага хурал хэвлэлээс хаалттай хуралдсан. Бага хурлын гишүүдийнхээ гар утсыг хурааж авсан. Хамгийн гол нь саналын хайрцгаа хөшигний ард задалж тоолсон.

Тэгэхээр энэ маань ардчилсан, ил тод, нээлттэй байх шударга зарчимд ер нь хэр нийцэж байгаа юм бэ?

Тэгээд одоо энэ Ардын намын хяналтын хорооны дарга байна, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга байна.

Ер нь цаашдаа улс төрийн намууд тухайн шатныхаа төлөөллийн байгууллагаараа Ерөнхий сайдыг сонгох, Их Хурлын даргыг сонгох, Ерөнхийлөгчийн сонгуульд хэн нэр дэвшихийг шийдэхдээ ил тод, нээлттэй, ардчилсан зарчмаар шударга сонгодог байх энэ нэг дүрэм журмаараа нийцүүлж ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм байна гэж харж байгаа.

Асуулт нь юу вэ гэхээр Та үүнийг өөрөө хувь улс төрчийнхөө хувьд юу гэж харж байгаа вэ?

Хоёрт нь, “эргэлзээтэй” зүйл. Өмнөх Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал дээр оруулж ирэхэд удаа дараа нэг зүйлийг хэлсэн... /минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Номтойбаяр гишүүнд 1 минут өгье.

**Н.Номтойбаяр:** Ерөнхийлөгчийн дэмжлэг байхгүй болсон. Зөрчилдөөд байна гээд. Яг тухайн зөрчил нь юу байсан юм бол?

Та Ерөнхий сайд болсноор энэ зөрчил хэвээр үргэлжлэх үү, эсвэл шийдлээ олох уу?

“Итгэл төрөхгүй байна” гэдэг дээр нэг зүйл дээр л би үнэхээр харамсаад л байгаа юм. Таныг ч нэг талдаа юу руу яваад орж байгаа бол гэдэг дээр хамгаалах ч гэх юм уу.

Засгийн газрын кабинетын зарчим алдагдсан. Өмнөх Засгийн газар дээр. Засгийн газраа огцруулахын төлөө ажилласан. Урвалт шарвалтууд маш их байсан. Энэ байдал улс төрд жишиг болж тогтлоо.

Та урьд нь хоёр ч удаа Засгийн газарт байсан. Ийм итгэл үнэмшилгүй кабинет Монголын улс төрийн түүхэнд бүрдэж байгаагүй.

Тэгэхээр итгэл төрөхгүй байгаад байгаа гэж миний хэлээд байгаа шалтгаан нь ердөөсөө энд л байгаад байгаа юм. Энэ улс төр бол... /минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Г.Занданшатар нэр дэвшигч хариулъя. Н.Номтойбаяр гишүүний асуултад.

**Г.Занданшатар:** Н.Номтойбаяр гишүүний асуултад хариулъя.

Ер нь нэгдүгээр агуулга яагаад нэр дэвшиж байгаа вэ гэдэг чиглэлтэй байна гэж ойлголоо.

Ер нь 2019 онд, дараа нь 2023 онд баталсан Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг амьдралд баталгаатай хэрэгжүүлж, хэрэгжилтийг нь хангаж амилуулахын тулд нэр дэвшиж байна гэж нэг талаасаа бодож болно.

Нөгөө талаасаа цагийн байдал хүнд, улс төрийн нөхцөл байдал зөрчилтэй, гадаад орчин маш хүнд байгааг ойлгож байгаа.

Энэ үед намын нөхөд болон төрийн нөхөд Ерөнхий сайдад итгэл хүлээлгэж байхад ухрах эрх байхгүй гэж бодсон. Тааламжтай үед урагшаа гардаг, хэцүү үед хойшоо суух эрх бидэнд байхгүй. Ингэж бидэнд сургасан. Үнэхээр байдал хүнд байгаа.

Ийм учраас меритийн зарчим, мэдлэг боловсрол, ажлын туршлага таарч байна, яв, зүтгэ гэсэн намын хамт олны итгэлээс хойш суугаагүй.

Намын Бага хурлын хувьд би намын дарга, удирдлага биш учраас төлөөлж хариулах бололцоогүй.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид Улс төрийн намын тухай хуулиар ил тод байдал, дотоод ардчилал бүх зүйлийг хуульчилж өгсөн. Улс төрийн намын тухай хуулийг баталсан. Энэ улс төрийн намын шинэчлэл бол

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу тууштай хэрэгжих ёстой л гэж бодож байна.

Намын Бага хурал дотооддоо нээлттэй, дотоод ардчилалтай явсан гэж ойлгож байгаа.

Эргэлзээтэй асуудлыг би яг тэр зөрчлийн субъект нь биш учраас дундуур нь ороод тайлбарлах боломжгүй.

Ер нь өнөөгийн нөхцөл байдал гаднаа ийм хүнд байхад, жижиг улсуудыг том улсууд шахаад Грийнландаас авхуулаад олон улсын геополитикийн зөрчил байдал хурцадмал болж байгаа энэ цаг үед гадаа хүйтэрч байхад

- дотооддоо бид дулаан байх ёстой,
- эв нэгдэлтэй байх ёстой,
- Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн институт эв нэгдэлтэй ажиллах ёстой,
- улс орныхоо том эрх ашгийг бодож ажиллах ёстой,
- парламентын ардчиллаа төлөвшүүлэх, төгөлдөржүүлэх ёстой,
- Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг тууштай хэрэгжүүлэх ёстой,
- Засгийн газрын хараат бус бие даасан байдлыг хангах ёстой.

Ийм л зарчмын үүднээс би нэр дэвшиж байгаа гэж бодож байгаа.

Хүнд цаг үеийг давж туулах, эвлэж зохицуулах ийм зарчим дээр ажиллаж байгаа.

Эзэн Чингис хааны үеэс эхлээд бид “эвдрэхдээ хуваагдахын хүрд байсан, эвлэрэхдээ бид үржүүлэхийн хүрд байсан”.

Ингэж байж бид энэ хүнд цаг үеийг үржүүлж байж дайна уу гэхээс биш хуваагдаж байж бид улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолын нөхцөл байдлыг ч гэсэн бодолцсон, эдийн засгийн аюулгүй байдлаа ч бодсон гэсэн ийм шийдэл гаргасан юм.

Үүнийг Н.Номтойбаяр дарга аюулгүй байдлын чиглэлээр судлаач хүн учраас ойлгож байгаа гэж итгэж байна.

Ер нь Засгийн газрын кабинетын зарчим алдагдаж байсан зөндөө тохиолдол бий. 50 хувь нь огцорч байсан. Үүнээс илүү хүнд улс төрийн нөхцөл байдлыг даваад гарч байсан. “Монголын заяа их” гэж бид ийм хүнд цаг үед “эвлэвэл бүтнэ, ховловол гутна” гэдэг шиг хамтарч ажиллаж байж л ард нь гарна.

Тийм учраас арагшаа харж биш урагшаа харж ажиллана. Эвийг эрхэмлэж ажиллаж байж бид өнөөгийн цаг үеийг давж, хүндрээд байгаа эдийн засгаа давна.

Би элдэв нарийн тоо хэлж ард түмэнд шок, хүлээлт үүсгэмээргүй байна. Хүндрэлтэй юмыг би одоо тоочмооргүй байна. Үүнийг бид Засгийн газрын түвшинтэй ярьж шийдвэрлэхийн төлөө ажиллана.

Нөхцөл байдлыг хамгийн сайн мэдэж байгаа хүн бол Н.Номтойбаяр дарга. Эдийн засгийн хүндрэлийг ч тэр, экспортын нөхцөл байдлыг ч тэр, улс төрийн нөхцөл байдлыг ч гэсэн.

Тийм учраас хамтарч ажиллахад бэлэн байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Э.Болормаа гишүүн асуултаа асууя.

**Э.Болормаа:** Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд өнөөдөр нэр дэвшигчдэдээ хандаад хоёр асуулт байна.

Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газар сая огцроход итгэл хүлээлгэхгүй байх нөхцөл үүсхэд, эргээд харахад таны дүгнэлт ямар байгаа вэ?

Мэдээж хүмүүс олон талаас өөр өөр дүгнэлтүүд хэлж байгаа байх. Та сая үгэндээ өөрөө “улс төрийн байдал зөрчилтэй байна” гэдэг энэ үгийг хэллээ.

Би яагаад үүнийг асууж байна вэ гэхээр яг юунаас болоод энэ Засгийн газар өмнөх хамтарсан Засгийн газар үргэлжилж чадахгүй байх нөхцөл бүрдсэн гэж үзсэнээс Та дараагийн Засгийн газраа бүрдүүлэхдээ болон дараагийн Засгийн газрын үйл ажиллагаандаа ямар өөрчлөлтүүдийг хийх вэ?

Тогтвортой Засгийн газар бол хамгийн сайн Засгийн газар гэж би хувьдаа үздэг. Тэгж байж ажил явдаг. Таны саяын хэлсэнчлэн эв нэгдэлтэй байх үедээ монголчууд бид байнга урагшилж ирдэг гэдэгтэй мөн санал нийлж байна. Тийм ч учраас миний хувьд хамтарсан засгийг дэмжиж ирсэн.

Тэгэхээр яг өмнөх Засгийн газраасаа ямар байдлаар өөрөөр ажиллаж, ялангуяа дангаараа засаглана гэсэн ийм байр суурьтай байгаа үедээ юугаараа өөр ажиллаж, эв нэгдлийг хангаж ажиллах вэ гэдэг асуултыг асууя.

Хоёр дахь асуулт нь, Төрийн байгуулалтын байнгын хороо учир дараагийн Засгийн газрыг бүрдүүлэхдээ Засгийн газрын тэргүүний хувьд Та бусад намуудыг урьж оролцуулах байр суурьтай байгаа юу?

Монгол Ардын намын Бага хурлаар гэрээгээ зөрчсөн гэдэг энэ томьёоллын яагаад ч юм гаргаж ирээд Ардчилсан намыг гаргах ийм үндэслэл гаргасан. Шулуухан хэлэхэд олон хүний гомдол явсан байх гэж бодож байна.

Тэгээд сандал, суудлын гомдлын асуудал, албан тушаалын гомдлын асуудал дээр дооргүй л явсан байх.

Тэгэхээр ийм нөхцөл байдал үүсэхгүйн тулд Та бусад жижиг намуудтайгаа хамтрах уу? Энэ байр сууриа намын удирдлагын түвшинд Та бүхэн ярилцсан уу?

Уучлаарай. Баярлалаа. Уучлаарай Б.Батбаатар дарга. Ардчилсан намаас бусад намуудтайгаа, бусад улс төрийн намуудтайгаа хамтрах саналыг тавихаар удирдлагын түвшинд ярилцсан уу гэдгийг тодруулъя.

Яагаад гэвэл яг энэ Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бид энэ асуудлыг ярилцах нь зүйтэй байх гэдэг үүднээс энэ байр суурийг өнөөдөр тодорхой асууя гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэр дэвшигч нэвшигч Г.Занданшатар хариулъя. Ж.Баярмаа гишүүн нэг асуултад нэмчхээрэй.

**Г.Занданшатар:** Э.Болормаа гишүүний асуултад хариулъя.

Одоо бид арагшаа биш, урагшаа харж ажиллах ёстой гэдэг дээр бүгд санал нэгдэж байгаа гэж ойлгож байгаа.

Улсын Их Хурлаар өдөржин шөнөжин хэлэлцээд гаргасан шийдвэрийг би өнөөдөр шүүж дүгнэдэг хүн биш. Улсын Их Хурлын шийдвэрийг цэцээс өөр хүн үнэлж дүгнэдэггүй.

Л.Оюун-Эрдэнийн Засгийн газрын талаар хангалттай сайн ажиллаж, олон мега төслүүдийг урагшлуулах, хамтарсан Засгийн газраас төмөр зам, дэд бүтцийн чиглэл, мега төслүүдийн чиглэлээр ажлуудаа урагшлуулж, авлигатай тэмцэх, Үндэсний баялгийн сангийн хуулийг амьдруулах талаар богино хугацаанд үр дүнтэй ажилласан гэж бодож байгаа.

Ийм учраас хувь хүний хувьд би Л.Оюун-Эрдэнийн Засгийн газрыг сайн ажилласан гэж дүгнэж байгаа.

Ер нь цаашдаа ч гэсэн энэ ажлууд үргэлжлэх ёстой гэж бодож байгаа. Сайн ажлууд бол.

Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намуудтай ярилцсан уу гэж. Ярилцаагүй ээ. Үндсэн хуулийн 39.3-д заасны дагуу Ерөнхий сайд энэ асуудлыг

ярьдаг. Би томилогдоогүй, сонгогдоогүй байгаа учраас тийм юм ярих бололцоогүй.

Хэрэв Улсын Их Хурлаас сонгогдож, итгэл хүлээлгэж, томилогдох юм бол Улсын Их Хуралд суудалтай намуудтайгаа хамтын ажиллагааны талаар ярилцана. Тэр ярилцах эрх үүснэ. Ярилцах ярилцахгүйгээ шийднэ.

Тэгэхдээ нэг хатуу юм бол Монгол Улсын эрх ашгийн төлөө аливаа төсөл дээр заавал Засгийн газарт орсноороо ч хамтардаг юм биш. Нийт Монгол Улсын эрх ашгийн төлөө ажиллана гэж тангараг өргөсөн нийт Улсын Их Хурлын гишүүд, намын бүлгүүд, намууд, Монгол Улсад хэрэгтэй сайн зүйлийн төлөө нэгдэж хамтарч ажиллах ёстой. Буруу зүйлийг нь шүүмжилж байх ёстой.

Ийм учраас хамтын ажиллагаа гэдэг бол их илүү өргөн утгатай ойлголт гэж би ойлгож байгаа.

Ийм учраас Монгол Улсын эрх ашгийн төлөө хэнтэй ч хамтарч ажиллана. Монгол Улсын эрх ашгийн эсрэг бол хэнтэй ч гэсэн бид эсрэг үг дуугарч тэмцэх ёстой ийм үүрэгтэй ажил гэж би ойлгож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Э.Болормаа гишүүнд нэмэлт 1 минут.

**Э.Болормаа:** Сая асуултдаа зүгээр тодруулга авъя.

Нэр дэвшигчээс. Та түрүүн үгэндээ “улс төрийн байдал зөрчилтэй байна” гэдэг энэ үгийг хэлсэн учир би эхний асуултыг асуусан юм. Яагаад тэгж үзэж байна вэ? Та яагаад тэр үгийг ашиглав гэдгийг тодруулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Г.Занданшатар нэр дэвшигч хариулъя.

**Г.Занданшатар:** Өмнөх асуултуудад “улс төрийн нөхцөл байдал зөрчилдөөнтэй, эдийн засгийн байдал хүндрэлтэй байна” гэсэн.

Ер нь дэлхий нийтийн улс төрийн нөхцөл байдал ч гэсэн зөрчилдөөнтэй, геополитикийн нөхцөл байдал ч гэсэн хуваагдмал, тарифын дайн, худалдааны дайн болж үргэлжилсэн зөрчилдөөнтэй дэлхийн гадаад, дотоод нөхцөл байдал байна гэдгийг онцолсон.

Өнөөдрийн улс төрийн нөхцөл байдал ч гэсэн Засгийн газар огцорч байна гэдэг маань тогтворгүй байдал, зөрчилдөөн байгаагийн илрэл гэж би бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** 2020-2024 оны хооронд парламентын гишүүнээр ажиллахдаа ард түмний 10 хуулийг санаачилсан.

8 хууль, 3 Их Хурлын тогтоолыг батлуулсан. Ихэнх нь ахмадуудтай холбоотой.

Энэ удаа ч гэсэн ард түмний 10 хуулийг санаачлаад явж байгаа.

Тэгээд энэ хуулиудын заримаас нь таны дэмжлэг ямар байгаа вэ гэдгийг асууя.

▷ **Нэгдүгээрт нь**, уул уурхай болон онцгой татвартай бараанаас бусад бараа, үйлчилгээг НӨАТ-ыг нь 5 хувь болгох хуулийг дэмжих үү?

▷ **Хоёрдугаарт нь**, хуурамч шатахууны эсрэг хууль байгаа. Энэ бол ард түмний машин тэргийг эвддэг, хүүхэд, хүмүүсийг хордуулдаг ийм гэмт үйлдэл байгаа. Үүнийг дэмжих үү?

▷ **Гуравдугаарт нь**, давхар АМНАТ-ийн хууль буюу уул уурхайн өөр аж ахуйн нэгж бараа, бүтээгдэхүүн баяжуулахад түүнээс нь давхар АМНАТ авдаг. Үүнээс болж 50 гаруй аж ахуйн нэгж дампуурсан. Үүнийг давхар АМНАТ-аар нь болиулж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих үү?

▷ **Дөрөвдүгээрт нь**, “Эрдэнэс Тавантолгой” хувьцааг **“САЙН ХУВЬЦАА”** нэрээр ахмадуудад 1 сая төгрөг өгөөд, оюутнуудад 300 мянган төгрөг төлбөр төлөөд, эрүүл мэндийн даатгал нэрээр баахан хүмүүсээс авсан.

Тэгээд энэ хүмүүсийн хувьцааг тухайн үед өгсөн мөнгөөр нь буцааж ард иргэд нь төлөөд, хувьцаагаа бүтэн болгох ийм хууль байгаа. Үүнийг авснаар тэр хүмүүс бүгдээрээ бүтэн “Эрдэнэс Тавантолгой” хувьцааг авах боломж нээгдэнэ. Энэ хуулийг дэмжих үү?

▷ **Тавдугаарт нь**, уул уурхайн ордоос Орос руу өргөн царигаар, Хятад руу нарийн царигаар төмөр зам барих Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Энэ бол төмөр төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого, бичиг баримтад нийцэж байгаа.

Тэгээд энэ тогтоолын төслийг дэмжих үү гэсэн ийм асуултууд байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** 5 номерын микрофон. Г.Занданшатар нэр дэвшигч хариулъя.

**Г.Занданшатар:** Нэмэгдсэн өртгийн албан татвар, ер нь татварын дарамт, нийт ард иргэдэд оногдож байгаа татварын хувь хэмжээг бууруулж, харин тансаг хэрэглээний татвар болон хэт өндөр үнэтэй барааны гэсэн үг л дээ.

Одоо жишээлбэл өндөр үнэтэй архи, тамхины импорт ч байдаг юм уу. Ийм татварыг нэмэгдүүлэх замаар татварын ачааллыг бууруулах гэсэн ийм агуулгын өөрчлөлтийг бид ярьж ирсэн.

Тэгээд бидний энэ санаачилгыг дэмжиж байгаа, дэмжиж хамтарч ажиллаж байсан Б.Пүрэвдорж гишүүндээ талархаж байна.

Тэгэхдээ нэмэгдсэн өртгийн албан татвар бол бусад татваруудтайгаа уялдаж, нийт ард иргэд төлдөг татварын дарамтыг бууруулах, төр бүсээ чангалах замаар төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлэх. Мөн хэт тансаг хэрэглээний өндөр үнэтэй архи, тамхи импортоор аваад л валютын ханшийг өсгөөд л байгаа. Тэгээд л хэт өндөр үнэтэй машин, сууц ч байдаг юм уу. Ийм татвар дэлхий даяар хэрэгжиж, зөвхөн төсвийн орлого бүрдүүлэх биш нийгмийн дундаж давхаргыг чиглэхэд дэмжсэн бодлогын хөшүүрэг нь татварын бодлого байдаг учраас энэ чиглэлийн татварын цогц реформ хийхийг би зорьж энэ ажил дээр голлож анхаарч тэргүүлэх чиглэл байх болно гэж бодож байгаа.

Ер нь хуурамч шатахуун төдийгүй хуурамч бүх юмтай л тэмцэх ёстой. Энэ хуулийг бид баталж байсан. Харамсалтай нь намайг эзгүйд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр энэ хууль хүчингүй болсныг Та сайн мэдэж байгаа.

Давхар АМНАТ-ын хууль ч гэсэн тэр. Дотоодын үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн бүх чиг хандлагуудыг бид дэмжиж байх ёстой.

Энэ нэмэгдсэн өртгийн албан татвар ч тэр, давхар АМНАТ ч гэсэн дотооддоо нэмүү өртөг шингээж байгаа, ажлын байр бий болгож байгаа, ажил олгогч баялаг бүтээгчдийг бид дэмжсэн бодлого хэрэгжүүлж байж л ажилгүйдэл, ядуурыг бууруулна. Ингэж байж бид эдийн засгаа сэргээнэ. Энэ бол миний бодлогын хатуу итгэл үнэмшил. Үндсэндээ бид үндэсний үйлдвэрлэгчдээ дэмждэггүй, өртөг нэмэхээр нь татвар оногдуулаад л дарамтлаад байдаг болох юм бол хэн Монголд нэмүү өртөг бүтээх вэ.

Ийм учраас эдийн засгийн аюулгүй байдлын хувьд ч тэр, эдийн засгийн өсөлтийн хувьд ч гэсэн тэр ажилгүйдэл, ядуурлыг буулгагчийн хувьд ч гэсэн тэр ажил олгогчид, баялаг бүтээгчдэдээ дэмжиж байж ажлын байр бий болж байж энэ ажилгүйдэл, ядуурал буурч нөгөө **“ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ”** гэдэг их гоё сайхан урианууд бодит амьдралд хэрэгжинэ. Энэ бол миний хувь хүний ч төдийгүй, улс төрийн итгэл үнэмшил.

Царигийн асуудал ч гэсэн ялгаагүй. Бид экспортоо дэмжиж байж л энэ валютын ханш чинь тогтворжиж, ард түмний амьжиргаанд сайнаар нөлөөлнө.

Тийм учраас ард түмэндээ ээлтэй, ард иргэддээ өгөөжтэй байхын тулд үнийн өсөлтийг хязгаарлах бодлого валютын ханшаас, бүр тодорхойлбол импортыг хэт дэмжсэн, экспортоо хязгаарласан бодлогуудыг чөлөөлснөөс л эдийн засаг сэргэх ёстой.

“Эрдэнэс Тавантолгой” менежментийг “менежментийн гэрээний зарчим”-аар, “Олон улсын Канадын зарчим”-аар, ер нь цаашдаа урт хугацаандаа нээлттэй хувьцаат компани болох Эрдэнэтийг ч гэсэн тэр, ийм **PUBLIC COMPANY** болгож байж үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлж, үр дүнтэй ажилладаг, хувийн хэвшлээ дэмждэг, хувийн хэвшилтэйгээ өрсөлддөггүй, хамтардаг энэ чөлөөт зах зээлийн болон төрийн зохицуулалтын оновчтой бодлогыг уялдуулж байж манай уул уурхай, дэд бүтцийн бодлого оновчтой хэрэгжих ёстой. Дэд бүтэцгүй уул уурхай гэж байхгүй.

Тийм учраас энэ бодлогыг хамтын шинэ механизмыг бүрдүүлэх чиглэлээр ажил аваад тодорхой болсон нөхцөлд дэлгэрэнгүй танд танилцуулж ярья гэж бодож байна. Ерөнхий зарчим тогтоолыг Та мэдэж байгаа шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Пүрэвдорж гишүүн нэмэлт асуулт асууя.

**Б.Пүрэвдорж:** Хуурамч шатахууны хуулийг бид хамтдаа баталсан боловч Үндсэн хуулийн цэцэд өгч, тэр хэдэн нөхдүүдийг авлигадаж, худалдаж авч миний хуулийг хүчингүй болгох ийм шийдвэр гараад, тэрийг нь Ардын намын гишүүд бүгдээрээ дэмжиж, тэнд янз янзын сонирхол орсон гэдэгт би огт эргэлздэггүй.

Зөвхөн сошиал дээр гэхэд нэг тэрбум төгрөгийг миний эсрэг зарцуулж байсан шүү дээ. Яг тэр хавар.

Тийм учраас Монголын хөгжилд саад болж байгаа “Евро-5” дэлхийд түүнээс дээшээ шатахуун хэрэглэж байхад Монголд “Евро-2” хэрэглээд ингээд байж байна гэдэг бол тэр хэт бага үнэтэй хуурамч шатахуун Монголын зах зээл дээр байснаас болж бүх машин тэргийг эвддэг, хуурамч шатахуун хэрэглэдэг, уул уурхайн томоохон техникууд эвдэрдэг ийм л байдалтай байгаа.

Тэгээд Монголыг хойш татсан ийм юман дээрээ Та нар хатуу байгаарай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэллээ. Ж.Баярмаа гишүүн асуулт асууя.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Одоо ерөөсөө Монгол Улс ямар түвшинд яаж явж байгааг нь олон улсын байгууллагууд л үнэлээд байгаа л даа. Бид нараас гадна. Зөвхөн сөрөг хүчин үнэлээд байгаа юм биш.

Тэгэхээр бид маш сайн мэдэж байгаа. Жишээлбэл, хэвлэлийн эрх чөлөөний индексээр Ардчилсан намын үе буюу 2015 онд 54 дүгээр байранд байдаг байсан боловчиг харамсалтай нь одоо 109 дүгээр байр. Хоёр дахин ухарсан. Хэвлэлийн эрх чөлөө. 2015 он.

Авлигын индекс бас Ардчилсан намын засаглалын үе буюу 2015 онд 72 дугаар байранд байсан бол одоо 121 дүгээр байранд очоод бараг 50-иад байраар ухарсан.

Энэ бол хамгийн чухал зүйл л дээ. Нөгөө шударга ёс, авлигатай холбогдож явж байгаа. Тийм ээ. Шударга ёс байхгүй учраас л энэ дарга анги чинь авлигад идэгдээд байна гээд явж байгаа.

Үүнээс гадна дахиад шударга ёс. Иргэдэд ээлтэй байна уу, дарга нарт ээлтэй байна уу гэхээр одоо энэ 230 мянга орчим төрийн албан хаагчдаас чинь 20 мянга орчим нь дарга сэтэртэй байна гэж байна.

Тэгэхээр Та энэ дарга сэтэртэй энэ орон тоонуудыг цөөлөх чиглэл рүү дорвитой ажиллагаа хийх үү?

Дахиад Ардчилсан намын засаглал буюу 1996-2000 оны хооронд 9-хөн яамтай, Ерөнхий сайдаа оруулаад Хэрэг эрхлэхийн газрын даргаа оруулаад 11 сайдтай үйл ажиллагаа явуулж байсан. Тэр үед улс төр, нийгэм, эдийн засгийн хамгийн гол гол реформуудыг маш амжилттай хийсэн.

Одоо Аргентины жишээг бид улиг болтлоо ярьж байгаа. Бүхэл бүтэн 47 сая хүн амтай мөртлөө 9 сайдтай.

Тэгэхээр та яг энэ төрийн албыг цомхон болгох, дарга сэтэртэнгүүдийг болиулах, төрийн өмчит компаниудыг олон нийтийнх болгох, хувьчлах, төрд байгаа асар их хөрөнгүүдийг зарж үрэх.

Каха Бендукидзе /KAKHA BENDUKIDZE/ гээд Та мэдэж байгаа байх. Тийм ээ. Гүржийн эдийн засгийн сайд.

“Ерөөсөө сүнснээсээ бусдыг худалд” гэж байгаа шүү дээ бараг.

Түүн шиг Та ийм дорвитой өөрчлөлтүүдийг яг хийж чадах уу? Та болсноосоо хойш хэлнэ гээд байх юм. Үгүй л дээ. Та чинь одоо болох гээд явж байгаа хүн учир танд өөрийн гэсэн нэг хараа, ёстой нөгөө алсын хараа гэдэг шиг юм байгаа байх. Тэгэхээр энэ асуудлууд дээр Та.

Хамгийн чухал зүйл Монгол Улс харамсалтай нэг дүн гарсан нь юу вэ гэвэл “V-Dem” /VARIETIES OF DEMOCRACY/ гээд. Тийм ээ. Байгууллагын ангиллаар “сонгуультай авторитар дэглэм”-д /ELECTORAL AUTOCRACY/ орсон. Үүнийг ерөөсөө ярихгүй байна.

Гэтэл энэ чинь аягүй ноцтой үзэгдэл шүү дээ. Уг нь. Манайх чинь нөгөө ардчилсан улс биш болсон явж байгаа байхгүй юу. Дүр эсгэсэн сонгууль хийдэг. Тэгээд бусад юм нь авах юмгүй гэсэн үг шүү дээ. Та өөрөө мэдэж байгаа. Тийм ээ.

“Сонгуультай авторитар дэглэм” гэдэг ямар дэглэмийг хэлдэг вэ гэвэл мэдээж сонгууль нь нэг юм болдог. **Free and Fair**. Гэхдээ энэ чинь мафантай.

Тэгэнгүүт нөгөө “шүүхийн засаглал бүрэн хараат бус” гэдэг дээр мафан байна. Хэвлэлийн эрх чөлөө мафан байна. Авлига... /минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэмэлт авах юм уу? Ж.Баярмаа гишүүнд нэмэлт 1 минут.

**Ж.Баярмаа:** Тэгэхээр Та бол бас ардчилалыг маш их ярьдаг хүн. “Зөвлөлдөх ардчилал”, “Шууд ардчилал” гээд.

Тэгэхээр энэ маш ноцтой зүйлийг Та ер нь юу гэж үнэлж байгаа вэ? Монгол Улсын өнөөдрийн энэ сонгуультай авторитар буюу бараг дарангуй дэглэмд орсон энэ байдлыг.

Та бас 100 мянган иргэдийн санал дээр их ач холбогдол өгдөг байсан. Их Хурлын дарга байхдаа.

Тэгэхээр өнөөдрийн байдлаар 100 мянган иргэн долоохон хоногийн дотор хувь хүний орлогын албан татварыг “1 хувь болго” гээд саналаа өгсөн явж байгаа.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүд энэ дээр хуулийн төсөл боловсруулаад Засгийн газраас санал авсан явж байгаа. Мэдээж Засгийн газар дэмжээгүй.

Тэгэхээр Та энэ 100 мянга гэдэг энд их ач холбогдлыг өгдөг гишүүн байсны хувьд, Улсын Их Хурлын дарга байсны хувьд энэ 100 мянган саналуудыг ер нь цаашид Засгийн газрын тэргүүн болох юм бол яаж авч үзэх вэ? Эдгээр саналуудыг дэмжих юм уу, эсвэл та өөр шалтгаанаар дэмжихгүй байх юм уу?

Хамгийн сүүлийн. Та ёс суртахуун... /минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Г.Занданшатар дарга хариулъя. Тэр дарга, менежер сэтэртэй хүмүүсийг яах юм гэж байх шиг байна.

**Г.Занданшатар:** Жудагийн Баярмаа гишүүний асуултад хариулъя.

Ер нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол энэ парламентын ардчилал төлөвшүүлэх, төгөлдөршүүлэхэд чиглэгдсэн.

Ийм учраас өрсөлдөөнд авторитаризм гэж байна уу, аль эсвэл сонгуульд өрсөлдөөнт ардчиллын тогтолцоог бэхжүүлэхийн тулд нэг нам хэт давамгайлсан парламентыг биш олон намын тогтолцоотой, жендэрийн эрх тэгш

байдлыг илүү хангасан ийм сонгуулийн тогтолцоог өнгөрсөн парламент хийж баталсан.

Үүний үр дүнд өнөөдөр парламентын ардчилал урагшаа алхаад явж байгаа гэж ойлгож байгаа.

Монголын ардчилал илүү шинэ шатанд гарч хөгжиж байгаа жишээ. Ганц жишээ дурдахад жендэрийн эрх тэгш байдлын индекс гэхэд сайжирсан. Манайх 18 хувьтай байж байгаад 35 хувьд хүрч, ер нь зарчмын хувьд хамгийн ихдээ л 17 хувийн эмэгтэй гишүүд төрүүлж байсан бол 32 эмэгтэй гишүүнтэй болсон нь түүхэн дээд амжилтыг 8 хувиар ахиулж 25 хувьд хүргэсэн нь парламент яаж **REPRESENTATIVE** буюу ард түмний төлөөлөх чадавх нэмэгдсэний тод жишээ. Төрийн бүх эрх мэдэл ард түмэн эх сурвалжтай буюу энэ ардчиллын гол индекс сайжрахад энэ бас нөлөөлнө гэж итгэж байна.

Харин энэ төрийн албыг цомхон, чадварлаг болгох ёстой. **DIGITAL POST** гэж орчин үед цахим төр, хиймэл оюун ухаан ашигласан ийм шинэчлэлтүүд хийгдэж байна. Энэ бол төрийн албыг цомхон, чадварлаг болгох, бас харьцангуй хараат бус, хөнгөн шуурхай болгоход чиглэгдсэн том реформыг хэрэгжүүлж гэж бодож байгаа.

**DIGITAL POST** буюу цахимаар шийддэг нэг цонхны үйлчилгээ Эстони, Гүржийн жишээнээс авхуулаад олон жишээг та мэдэх учраас би товчильё гэж бодож байна.

Ер нь энэ индексүүдийг бүгдийг нь ярих юм бол өгсөж, уруудсан олон тоонууд бий. Энэ дотроо хэвлэлийн эрх чөлөөний индексийн буурсан нэг шалтгаан гэхэд улс төрчид хэвлэл мэдээллийн байгууллагыг эзэмшдэг нь хэвлэлийн эрх чөлөө буурах нэг шалтгаан болж байна гэсэн дүгнэлт байх жишээтэй.

Тэгээд үүнийг чөтгөр детальд нуугддаг учраас нарийвчлан харж бид деталиуд дээр ажиллах шаардлагатай. Хуулийн зохицуулалт хийх шаардлагатай.

Энэ дээр Жудагийн Баярмаа гишүүн энэ дээр санаачилгатай хамтарч ажиллана гэдэгт итгэж байна.

Ер нь төрийн өмчийн компаниудын тоог хоёр дахин бууруулах, өмч хувьчлал, менежментийн гэрээ, **PUBLIC COMPANY** болох, хувьцаат болгох гэсэн ийм олон төрөл хэлбэрээр төрийн өмчийн реформыг хэрэгжүүлж, илүү үр ашигтай, ард түмэндээ нээлттэй, үр өгөөжтэй болгох чиглэсэн өөрчлөлт хийнэ гэж бодож байгаа.

Энэ талаар тусдаа төрийн өмчийн компаниудын реформын хуулийг өнгөрсөн парламентад бид ажлын хэсэг байгуулаад ажиллаж байсан боловч харамсалтай нь эцэслэн баталж чадаагүй.

Энэ хууль эрх зүйн шинэчлэл хийхэд манай ийм үзэл санаатай гишүүд маань хамтран ажиллана гэдэгт итгэж байна. **D-PARLIAMENT**-ын хувьд 100 мянга гэдэг тоог тэнгэрээс аваад тавьсан тоо биш.

Ер нь эцсийн эцэст шийдвэр гаргах эрх нь Их Хуралд хадгалагдсаар байх болно. Гэхдээ ард иргэдийнхээ дууг сонсдог, нээлттэй байхын тулд цахим парламентын платформыг нээсэн.

Мэдээж үүнийг зөвхөн ард иргэдийн саналаас гадна шинжлэх ухааны үндэстэй, бодит нөхцөл байдал дээрээ тулгуурлаад санал ийм байгаа юм шүү, үүний уг учир шалтгаан юу юм бэ гэдгийг судлаад шийдэл гаргаад явуулахад төсвийн орлого, зарлагад нөлөөлөх хувь, энэ олон шалтгааныг бодох ёстой.

Тийм учраас жишээлбэл, нэмэгдсэн өртгийн албан татвар дээр нийт ард иргэд дээр ногдож байгаа татварыг хэт тансаг хэрэглээний буюу баялгийн татварыг хослуулах замаар, татварын шударга бус тэгш байдлыг хангах замаар олон өөрчлөлт хийх ийм судалгааны ажлуудыг эцэслэж байж, кабинетын зарчим дээр тохирч байж оруулж ирдэг учраас би ярьдаг биш хийдэг, бас үнэнтэй тулдаг Ерөнхий сайд байхын тулд өнөөдөр би амлалт өгөөд баймааргүй байгаа учраас би асуудлаа шийдэж байж, бат нот тодорхой болгож байж тухайн үед нь оруулж ирье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ж.Золжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Золжаргал:** Нэр дэвшигчээс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тал дээр яаж ажиллах болоо гэсэн нэг тийм болгоомжлонгуй, санаа зовнингуй ийм байр суурь их олон сонсогдоод байгаа юм.

Тэгээд энэ дээр таны байр суурийг сонсох хэрэгтэй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын, шууд хөрөнгө оруулалтын үзүүлэлт сүүлийн хэдэн жил унаад, ер нь хандлага нь шалдаа уначхаад байгаа. Нөгөө талдаа болохоор гуравдагч хөрш гээд айхтар бодлого яриад байдаг. Мөнгө бодохгүй, эдийн засаг байхгүй бол тэр нь уриа маягийн болоод байдаг.

Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалт, тэр тусмаа гурав дахь улсуудын хөрөнгө оруулалтыг татах, дэмжих чиглэлээр Та ямар бодолтой байгаа вэ?

Тэгээд Монгол Улс чинь бас гадаад харилцаа идэвхтэй ийм улс. Олон улсад Элчин сайдын яамдтай. Элчин сайдуудтай энэ эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр хэрхэн хамтарч ажиллана гэж бодож байна вэ гэсэн ийм асуулт байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** 5 номерын микрофон. Г.Занданшатар нэр дэвшигч.

**Г.Занданшатар:** Нэгдүгээрт, гадаадын хөрөнгө оруулалт, ер нь дотоодын ч аливаа хөрөнгө оруулалтыг дэмжиж байж эдийн засагт ажлын байр бий болж, шинэчлэлт хийгдэх нь ойлгомжтой. Үүнийг ярьдаггүй эдийн засагч гэж нэг ч байхгүй.

Гадаадын хөрөнгө оруулалтын 2012 оны хууль тухайн үед Монголын баялгийг гадаадад чөлөөтэй зарагдаад, тэр нь хэмжээ хязгаарлалтгүй байх юм бол Монголоос зөвшөөрөл авдаг тухай агуулгатай л хууль байсан.

Жишээлбэл, хэвлэл мэдээллийн салбарт бүх телевизээ гадаадын хөрөнгө оруулалттай компани, хөрш орнуудын ч байна уу, Америкийн, Германы ч байна уу 100 хувь болбол энэ ард иргэдэд ямар мэдээлэл хүргэх вэ.

Аль эсвэл одоо нөгөө стратегийн орд газрын чинь Оюу Толгой нэг өдөр өөр Оросын ч юм уу, Хятадын ч юм уу, Америкийн ч юм уу компанид Монголд мэдэгдэхгүй зарсан байвал яах вэ. Яг ийм нээлт байсныг зөвхөн зөвшөөрөл авдаг тухай хуулийг яг Австралийн гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн жишгээр боловсруулж өргөн барьсан юм.

Мэдээж яах вэ сонгуулийн жил байсан учраас гишүүдийн нөгөө попролт, янз бүрийн шалтгаанаас тодорхой хуулийн анхны зарчим өөрчлөгдөөд, зарим салбарууд нэмэгдээд ингээд энэ хууль батлагдсан.

Тэгэхдээ энэ хууль хэрэгжилтийн шатдаа хэрэгжээгүй. Нэгт.

Хоёрт, энэ хуулийг дараа нь хүчингүй болгосон.

Тэгэхээр энэ хүчингүй болсон хуулиас болоод өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалт буураад байгаа юм байхгүй. Энэ бол хууль эрх зүйн тогтворгүй байдал, шүүх засаглал, авлигал, хээл хахууль, тэгээд орон нутгийн болон бүх шатны дарамт шахалтууд уул уурхай дээр. Маш олон хүчин зүйлээс шалтгаалж байгааг нэг нэгээр нь харж үзэхгүй бол нэг л нэг хуулиас болоод л бүх хөрөнгө оруулалт зогсоод байсан шиг алдаа дутагдалтай ойлголт.

Жишээлбэл, сая өнгөрсөн зун яригдсан тэр газартай холбоотой асуудал бол тэртээ тэргүй Газрын хуулиараа зохицуулагддаг, Хөрөнгө оруулалтын хууль нь дагаж мөрдөгддөггүй. Татварын хууль нь ч гэсэн өөр мөртлөө татварын хуулиа л барьдаг. Нөгөө бусад органик хуулиараа зохицуулагддаг гэдэг хууль Хөрөнгө оруулалтын хуульд орсон боловч бусад салбар хуулиудаа ороогүй учраас тэр хэрэгждэггүй тийм заалтууд шүү дээ. Тэр газрын асуудал ч гэсэн. Үндсэндээ тэр хэрэгждэггүй заалтууд байхгүй юу.

Тэгээд энэ бүхнийг хөрөнгө оруулалтын эсрэг юм шиг ойлгуулдаг, тайлбарладаг, түүнд нь автдаг хүмүүсийг би нөгөө **AmCham /AMERICAN CHAMBER OF COMMERCE/**, олон улсын байгууллагуудтай ярилцахаар шал өөр юм ярьдаг. Судалгаа шал өөр нотолдог.

Ийм учраас хөрөнгө оруулалтыг дэмжинэ гэдэг бол зүгээр нэг хуулийн тогтвортой байдал, улс төрийн тогтвортой байдал, олон хүчин зүйлээс шалтгаална.

Хамгийн наад зах нь баялаг бүтээгчид, ажил олгогчдодоо ингэж төр хандах хандлагаа өөрчилж байж энэ хөрөнгө оруулалт. Дотоодын хөрөнгө оруулагчдаа хайрлахгүй бол яаж гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх юм бэ. Тийм ээ.

Ийм учраас ажил олгогч, баялаг бүтээгчдээ дэмждэг цогц бодлого хэрэгжүүлж байж энэ ажил хэрэгжих ёстой гэж бодож байгаа юм.

Тийм учраас хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татахын тулд татварын тогтвортой байдал, хууль эрх зүйн орчны тодорхой байдал, мөн хөрөнгө оруулалтыг нээлттэй ил тод байдлаар хангах явдал хамгийн чухал.

Ийм учраас Хэрэг эрхлэх газрын дарга ажиллаж байхдаа би **PPD** буюу **PUBLIC PRIVATE DIALOGUE** гэдэг хөрөнгө оруулагч, хувийн хэвшлийн Засгийн газар, Улсын Их Хуралтай харилцах түншлэлийн зөвлөлийг байгуулж байсан. Энэ механизмыг үргэлжлүүлэх шаардлагатай байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Түрүүн Б.Баярбаатар гишүүн асуулт асуух гэж байсан нь үг болгоод явах шиг боллоо. Хөдөө аж ахуйтай холбоотой асуудал. Би нэг ганц асуулт асуугаадахъя.

Ер нь хөдөө аж ахуй, тэр тусмаа мал аж ахуй тал дээр ер нь ямар бодлого барих юм бэ? Г.Занданшатар дарга аа.

Малаас гарч байгаа түүхий эд боловсруулдаг үйлдвэрлэлийнхээ асуудал, ажлын байрыг бий болгох, орлогыг нэмэгдүүлэх, гадаад экспортын асуудлууд, гадаадаас орж ирж байгаа импортыг нөхөх асуудлууд, жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбоотой асуудлууд, малын өвчинтэй хэрхэн тэмцэх холбоотой асуудлууд.

Тэгээд Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” чинь үүнтэй бүхэлдээ хамааралтай байж байгаа шүү дээ.

Тэгээд энэ дээр нэг товчхон шиг нэг хариулт хэлээдхээч. Ямар бодлого баримтлах юм бэ? Яг үнэндээ түрүүний Засгийн газрын, тэр тусмаа Ерөнхий

сайдын амнаас хөдөө аж ахуйтай холбоотой, мал аж ахуйтай холбоотой маш бага дурдагдаж яригдсан асуудал байгаа шүү.

Тийм болохоор энэ дээр нэг хариулт өгөөдхөөч. 5 номер. Г.Занданшатар нэр дэвшигч.

**Г.Занданшатар:** Монголын мал аж ахуйн онцлогтой.

Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайдаар ажиллаж байх үедээ бид анх мал аж ахуйн талаар баримтлах, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын шинэчлэлийг хийж, дотооддоо энэ тариа, ногоогоо ургуулдаг болохоос авхуулаад, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих цогц бодлогыг хэрэгжүүлж ирсэн.

Тэгэхээр зөвхөн 200 мянган малчин өрх, 300 мянган малчны асуудал биш. Үүний цаана нүүдлийн соёл, иргэншлийн асуудал, хүнсний аюулгүй байдлын асуудал, хөдөөгийн хөгжлийн асуудал гээд цогц бодлогын асуудал шийдэх ёстой.

Энэ хүрээнд зөвхөн “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”, “ХОРШОО”, “ЦАГААН АЛТ” зэрэг хөтөлбөрүүд. Бодлого тодорхой байгаа. Манай. Үүний хэрэгжилт дээр анхаарах ёстой. Экспортын зах зээлийг бий болгох ёстой. Адаглаад ноолуураа бүрэн боловсруулаад гарахад манай Ж.Бат-Эрдэнэ гишүүний ахалдаг Ноос, ноолуурын холбоо энэ чиглэлээр эрчимтэй ажилладаг. 1 тэрбум долларын экспортын орлогыг нэмэгдүүлэх бололцоотой.

Манай Б.Баярбаатар гишүүний хэлдгээр **“ухдаг шар алтнаас ургадаг цагаан алтаа боловсруулдаг”** болоход ухаад алга болох биш, байнга нөхөн төлжиж, өсөн үржиж байдаг энэ ноос, ноолуураа боловсруулахад л зөвхөн 1 тэрбум долларын шинэ нэмүү өртөг шингээж баялаг бүтээх ийм бололцоотой.

Энэ гадаад зах зээлийг нээх ажлууд эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээр, бусад хэлбэрээрээ зөвхөн нэг улсаас хамааралтай экспортын төрөлжилтийг бий болгох чиглэлээр томоохон алхмуудыг хэрэгжүүлж, зах зээлээ бий болгож байж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж байж мал аж ахуйн талаар цогц бодлого хэрэгжинэ.

Энэ чиглэлээр энэ “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”, “ЦАГААН АЛТ” хөтөлбөрүүд. Үүний уялдаа холбоог нь хангасан, хамгийн гол нь хэрэгжилтийн ажил чухал гэж бодож байна.

Энэ чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа их чухал байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зайлшгүй нэг асуухгүй бол болохгүй асуудал байна. Энэ орон нутгийн бие даасан байдлыг сайжруулахын тулд энэ босоо удирдлагуудаа яах юм?

Одоо ер нь аймаг, орон нутаг дээр ажиллаж байгаа агентлагууд дан босоо болчхоод байна шүү дээ. Тэр Засаг даргад харьяалагддаг, Засаг даргын үгэнд ордог агентлаг байхгүй болчхоод байна. Энэ дээр та нэг хариулт өгөөч. Бүгд босоо болчхоод байна.

Г.Занданшатар нэр дэвшигч. 5 номер.

**Г.Занданшатар:** Ер нь Үндсэн хуулийн зарчим орон нутгийн хэвтээ удирдлагын тогтолцоо, унитарный буюу нэгдсэн улсын босоо удирдлагын тогтолцооны огтолцол дээр орон нутгийн удирдлагын зарчим хэрэг бичих ёстой гэсэн ийм суурь зарчимтай.

Тийм учраас энэ бол орон нутгийн санал, зөвлөмжтэйгөөр гарцаагүй босоо удирдлагатай байх агентлагууд гэж байна. Орон нутагтаа шийдээд явах ёстой. Увс аймгийн Давст сумд ямар болсон хүчин байна гэдгийг эндээс шийдээд байх боломжгүй гэсэн энэ хоёр хязгаар дотроос зөв боловсон хүчний сонголт хийдэг энэ механизм орон нутгийн саналыг үндэслээд босоо удирдлага, бодлоготой зайлшгүй шаардлагатай цагдаа ч байдаг юм уу, энэ газрууд дээр томилгоо хэрэгжүүлдэг. Сумын сургууль, нийгмийн даатгал гэх мэт энэ татварын тогтолцооны асуудлууд дээр.

Үүнийг чиглэл чиглэлээрээ ялгаатай авч үзэхгүй бол тусгай хүчний байгууллага... /минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Боловсон хүчнийхээ өнцгөөс хараад байвал орон нутаг чинь хөгжихгүй болчхоод байна шүү. Боловсон хүчний асуудал дээр.

Гишууд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Э.Болормаа гишүүнээр тасалъя. С.Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Одоо манай парламент үндсэндээ хэлэлцэгч парламент байсан бол одоо ер нь мэтгэлцээний парламент руу орох юм шиг байна.

Өнгөрсөн хугацаанд би Ардчилсан намын нөхдүүдээ ч бай, бусад улсууд ч бай ярьж байхад их хүндэтгэлтэй сонсож, бас заримдаа тэвчиж сонссон гэдгээ хэлье.

Гэхдээ бид заримдаа мэдээлэл өгөхдөө, зарим асуудалд хандахдаа судалгаанд суурилсан байдлаар, бодитой бүрэн нотолгоотой ярьж байхгүй бол нийгмийг араасаа бид дагуулж явж байгаа улсууд, буруу мэдээлэл өгөх вий гэдгийг эндээс анхааруулмаар байна.

Улсын Их Хурлын дарга энд сууж байна. Улсын Их Хурлын дарга маань ч гэсэн байнга өөрөө сонсоод сууж байгаа учраас энэ дээр бид хамтарч ажиллаж байгаа. Парламент дээр үүнийгээ ярьж гэж байгаа юм.

Сая Ж.Баярмаа гишүүн Монгол Улс сонгуулийн авторитар дэглэм рүү шилжлээ гэдэг судалгааны шинэ үр дүн гарлаа гээд ярьж байна. Яг ямар эх үүсвэрээс, хаанаас ярьж байгаа нотлохгүй бол нийгэм буруу ойлгох вий гэж байгаа юм.

Авторитизм гэдэг бол өөрөө дэглэм шүү дээ. Бид ардчилсан дэглэмтэй улсад амьдарч байгаа.

Түүнээс гадна 1990-ээд оны дунд үеэс хойш улс орнуудын чинь засаглалын ямар түвшинд байгааг, ямар хэлбэртэй байгааг тогтоодог олон улсын том судалгааны байгууллага байж байгаа.

Би сая утас руу шүүгээд шууд гурав тогшоод л орлоо. **FREEDOM HOUSE** гэж олон улсын байгууллага байгаа. 1990 оноос хойших энэ улс орнуудын засаглалын индексийг тогтоож байгаа.

Өнөөдөр 2025 оны байдлаар Монгол Улс “чөлөөт бөгөөд ардчилсан” гэдэг энэ ангилалдаа байсаар байна. Энэ дээр

- улс төрийн эрх, эрх чөлөөний асуудлыг 40 оноогоор үнэлэхэд 36-тай,
- иргэний эрхийг үнэлгээ 60 байхаас 48-тай байгаа юм.

- Бүхэлдээ 100 байхаас 84 гэсэн ийм үнэлгээ гарч байгаа юм.

Тэгэхээр нийгмийг бид ингэж төөрөгдүүлж ерөөсөө болохгүй. Хариуцлагатай байна шүү нөхдүүд минь.

Судлаачид байхгүй юм шиг, аливаа асуудлыг мэддэг хүн байхгүй юм шиг бид ингэж хандаж ерөөсөө болохгүй. Энэ дээр бид мэргэшсэн парламент байгаа бол мэргэшсэн парламентын түвшинд байя.

Би олон нийтийг ч гэсэн, хэвлэл мэдээллийг ч гэсэн зөв мэдээллийн талд байгаасай гэж уриалж байна. Би 10 сар үнэндээ тэвчсэн. Олон зүйлийг тэвчсэн шүү. Яг үнэнийг хэлье. Цаашдаа энэ бол цэвэр мэтгэлцээний парламент байх юм бол бид өөр өөрийн мэргэшсэн чиглэлээр мэтгэлцээд явахад бэлэн байгаа шүү гэдгийг бас эндээс илэрхийлж байна.

Хоёр дахь зүйл. Сая би Г.Занданшатар даргатай нэг зүйл дээр санал нэгдэж байна.

2019 оны 11 сарын 14-нд бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Үүгээрээ бид яасан гэхээр парламентын ардчилралыг, парламентын

засаглалыг бэхжүүлэх шийдвэр гаргасан. Ерөнхий сайд чинь кабинетаа өөрөө бие дааж бүрдүүлдэг, сайд нараа өөрөө бие дааж томилдог, шаардлагатай хариуцлагыг өөрөө бие даагаад хариуцлага хүлээлгэдэг ийм тогтолцоо руу шилжсэн.

Тэгэхээр бид ямар нэгэн байдлаар Үндсэн хуулиараа ч гэсэн ардчилсан засаглалыг бэхжүүлэх чиглэлийн өөрчлөлт хийгээд явж байгаа гэдгийг олон нийт мэдэж байх ёстой.

Гэхдээ манай нийгэмд асуудал бий. Сая Ж.Баярмаа гишүүний ярьсан хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой асуудал байна. Одоо бид Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг оруулж ирсэн. Үүнийгээ бид тал талаасаа яриад илүү боловсронгуй сайн болох чиглэл рүү ажиллах ёстой.

Тэгэхээр бодитой ярих ёстой гэдэг үүднээс би үүнийг зориуд хэлж байгаа шүү гэж байгаа юм.

Гурав дахь зүйл. Г.Занданшатар дарга аа, та өөрөө сайн мэдэж байгаа. “АЛСЫН ХАРАА-2050”-ийг боловсруулахад бид “Алсын хараа-2050”-ийн хүрээнд ойрын 10 жилийн манай жишээ нь төрийн албаны шинэчлэл яаж явах юм бэ гэдэг дээр нэг ойлголт байгаа. Үүнийг би бүр зориуд таныг анхаараасай гэж бодож байгаа юм.

Цомхон чадварлаг биш ээ. Зохистой, чадварлаг шүү.

Эрхэм Их Хурлын гишүүд ээ, цомхон байна уу, эсвэл том байна уу гол нь биш.

Та сая хэллээ шүү дээ. Муур хар байна уу, цагаан байна уу хамаагүй хулгана барьдаг байх ёстой буюу ажилладаг байх ёстой, бүтэц байх ёстой. Тэр үүднээс нь аваад үзэх юм бол цаашдын өөрчлөлт зохистой байх ёстой шүү гэж байгаа юм.

Тэр цэцэрлэгийн багш нар чинь хэрэгтэй юу хэрэгтэй, багш нар хэрэгтэй юу хэрэгтэй, эмч нар хэрэгтэй юу хэрэгтэй. Магадгүй захиргааны бүтэц дээр, дунд түвшний менежмент дээр бид цомхон болох ёстой юм бол тэндээ л ярина гэж байгаа юм.

Тэгэхээр би үүнийг зориуд тэмдэглүүлж байна шүү. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ц.Сандаг-Очир гишүүн үг хэлнэ.

**Ц.Сандаг-Очир:** Би Л.Оюун-Эрдэнийн Засгийн газрыг тогтвортой байх ёстой гэдэг байр сууриа маш тодорхой илэрхийлж байсан гишүүн байгаа юм.

Учир нь асуудал нь Л.Оюун-Эрдэнэдээ биш юм. Монгол төрийн Засгийн газар дараа дараагийн Засгийн газрууд үргэлж тогтвортой, чадвал бүрэн эрхээ дуусгадаг байх энэ бодолтой, байр суурьтай байдаг гишүүний хувиар энэ үгээ илэрхийлж байсан.

Тэгээд Монгол Улсын Засгийн газар огцрох болгондоо л Монголын ард түмэн хохирдог, Монгол төр сулардаг, талцаж хуваагддаг, бие биедээ чөдөр тушаа болдог, гадаадын хөрөнгө оруулалт дайждаг ийм л сөрөг үр дагаврууд гардаг учраас үе үеийн Засгийн газар тогтвортой байх ёстой гэдэг ийм бодол, байр суурьтай байдгаа илэрхийлж байсан юм.

Мөн Монгол Ардын намын 7 дугаар Бага хурал дээр миний бие заалнаас тантай хамтарч нэр дэвшиж байсан. Г.Тэмүүлэн гишүүнийг дэмжиж байна гэдгээ илэрхийлж байсан гишүүн байгаа юм.

Учир нь Монгол Ардын нам дотооддоо ардчилалтай нам юм. Хоёр, гурван хүний үгээр явдаггүй юм. Дараа дараагийн бэлтгэгдсэн боловсон хүчнүүд олон байгаа шүү гэдгийг нийгэм, олон нийтэд таниулах үүднээс Г.Тэмүүлэн гишүүнийг дэмжсэнийг бас дэмжиж үг хэлж байсан учир шалтгаан нь энэ юм.

Тийм учраас нэгэнт Их Хурлын болоод намын шийдвэрүүд гарсан учраас дараагийн шинэ Засгийн газар удахгүй байгуулагдана. Миний бие цаашдаа ч гэсэн дараагийн шинэ Засгийн газрыг тогтвортой байлгах тал дээр нь өөрийнхөө хэмжээнд чадах чинээгээрээ дэмжиж ажиллана.

- ▶ Ингэж байж Монгол төр тогтвортой байх ёстой,
- ▶ Монгол төр хүчирхэг байх ёстой,
- ▶ Монгол төр эв нэгдэлтэй байх ёстой,
- ▶ эдийн засаг тогтвортой байх ёстой,
- ▶ талцал хуваагдал багатай байх ёстой.

Ингэж бодож явдаг гишүүнийхээ хувиар ийм асуудлуудыг үүсгэж байсан.

Г.Занданшатар дарга Ерөнхий сайд болбол олон талын давуу талууд гарах байх гэж би хувьдаа бодож байгаа.

Миний хувьд харвал Та өнгөрсөн 8 жил парламентын дарга хийхдээ 2024 онд НӨАТ-ын асуудлыг ярьж байсан. Өөрөө санаачилж байсан. НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх асуудлыг өөрөө санаачилж, тухайн үеийн Сангийн сайдтай хүртэл мэтгэлцээн хийж, сайн муугаараа ярилцаж байсан үеийг би хажууд чинь хараад сууж байсан.

Би тэр ажлын хэсэгт чинь бас орж ажиллаж байсан.

Тийм учраас та бол одоо Ерөнхий сайд болбол энэ НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх асуудлаа бас эрчимтэй хийх ёстой. Энэ талаасаа давуу байх юм байна гэж би хувьдаа харж байгаа. Харж байгаа.

Нөгөө талаар сая Ж.Бат-Эрдэнэ даргын хэлж байгаа. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг үнэд оруулах, боловсруулдаг, хагас боловсруулдаг байх асуудлыг Та цааш цаашдаа шинэ шатанд гаргах хэрэгтэй байна.

Өнөөдөр жалгын нэг хаягдаж байгаа, үнэгүйдэж байгаа энэ арьс ширээ, ноос, ноолуурынхаа асуудлыг бид боловсруулж чадахгүй бол энэ хэт уул уурхайд шүтсэн улс төр чинь, эдийн засаг чинь хэзээ нэгэн цагт энэ чинь дуусдаг юм шүү.

Тийм учраас хөдөө аж ахуйн салбар, мал аж ахуйн салбараа хагас боловсруулсан бүтээгдэхүүн хийдэг, боловсруулдаг, гадагшаа урсаж байгаа валютыг дотроо шингээдэг байх энэ асуудлыг онцгой анхаарал хандуулж ажиллахыг хүсэж байгаа.

Нөгөө талаар хувийн хэвшлээ дэмжиж ажиллах асуудал байна. Эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлахгүй бол төрд итгэх итгэл чинь алдарч байна. Бүх зүйлд төр оролцож байна.

Тийм учраас энэ хувийн хэвшлийнхэн чинь өдөр ирэх тусам уур бухимдал нь хүрч байгаа учир шалтгаан нь ерөөсөө энэ.

Тийм учраас чөлөөт эдийн засгийг, хувийн хэвшлийнхнээр хийж болох бүх ажлыг энэ хувийн хэвшлийнхнээр хийлгэх асуудал дээр Ерөнхий сайдынхаа хувьд санал санаачилгатай ажиллаарай гэдгийг миний бие дахин хэлж байгаа юм. Баярлалаа. Амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Номинчимэг гишүүн үг хэлнэ.

**О.Номинчимэг:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Юуны өмнө Г.Занданшатар даргатай бас ажиллаж байсан хүний хувьд яг энэ цаг мөчид улс орны эдийн засгийг сэргээх, дараа дараагийн өсөлтийг авчрах энэ ажилд Г.Занданшатар дарга өөрөө юмыг их ул суурьтай хардаг, олон талын судалгаа, нотолгоон дээр суурилж шийдвэр гаргалтыг хийдэг хүний хувьд ийм шийдвэрүүдийг гаргаад аваад явах чадвартай, туршлагатай ийм хүн гэж харж байгаа. Дэмжиж байгаа.

Тэгээд Г.Занданшатар дарга 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж, парламентын засаглалыг бэхжүүлэх, үүнээс улбаалсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль гээд хуулийг санаачлан батлуулж байсан. Засаглалын тэнцвэрт байдал дээр нэлээн анхаарч ажилласан ийм улс төрч байгаа.

Тэгэхээр гүйцэтгэх засаглалыг толгойлж ажиллах хүний хувьд энэ хуулиудыг хэрэгжүүлэх, зөв зарчимд нь оруулах ажлууд дээр анхаарч ажиллах байх гэж харж байгаа.

Ер нь эдийн засгийн нөхцөл байдлыг харахаар бид нэлээн хүндэрсэн нөхцөл байдалтай байна.

Тэгэхээр шинээр бүрдэх Засгийн газарт нэлээн том ачаанууд ирэх төлөвтэй байна гэж харж байгаа.

2025 оны эхний 5 сарын байдлаар статистик л мэдээллийг харахаар манай экспортын орлого 14.7 хувиар буурсан. Төсвийн зардал 9.8 хувиар буюу 760 тэрбум төгрөгөөр өмнөх онтой харьцуулахад ихэссэн.

Тэгээд үнийн дүн нөгөө нүүрсний үнээс болоод 41 хувиар экспортын орлого буурахад энэ нүүрсний үнэ нь нэлээн нөлөөлсөн. Мөн инфляц энэ оны эхний 5 сарын байдлаар 8.3 хувьтай байна гэсэн ийм үзүүлэлтүүд байна.

Тэгэхээр макро эдийн засгийн хувьд ч гэсэн бид эдийн засгийн тогтвортой байдал, Сангийн яамны бодлого маш чухал байгаа.

Тэгэхээр Засгийн газраа бүрдүүлэх дээрээ энэ талын сайн боловсон хүчин, сайн шинэчлэл хийх ийм боловсон хүчнүүдийг цуглуулж ажиллаасай гэж бодож байгаа.

Сая гишүүд ч гэсэн дурдаж байна. Г.Занданшатар дарга ч гэсэн өөрийн бодлогодоо баримталж ажиллах юм бол ард иргэдийнхээ амьдралд хүрсэн бодлого шийдвэрүүдийг гаргана гээд.

2024 онд манай Монгол Улсын нэг хүнд оногдох **GDP** буюу дотоодын нийт бүтээгдэхүүн 5 мянган долларт хүрсэн гээд олон улсын ангиллаараа бид чинь **upper-middle-income** буюу “**дундажаас дээш орлоготой улс**”-д орчхоод байгаа.

Тэгтэл Сангийн яамнаас гаргаж байгаа албан тоогоор манай хүн амын нийт 90 хувь нь албан орлогын хувьд сарын 3.5 сая төгрөгөөс доош байна гэдэг харагдаж байгаа юм.

Эндээс юу харж байна гэхээр бид ерөөсөө баялгийн тэгш хуваарилалт байхгүй байна. Энэ эдийн засгийн өсөлт ерөөсөө нийт ард иргэдэд сайн очихгүй байна гэсэн дүн гарч байгаа.

Тэгээд ер нь эдийн засгийн хамгийн шударга үзүүлэлт бол иргэн Баяраагийн түрийвч л байх ёстой. Иргэн Баяраагийн түрийвч өнөөдөр өндөр

байна уу, худалдан авах чадвар сайн байна уу гэдгээр л бид эдийн засгийнхаа өсөлтийг хэмжих ёстой.

Тэгэхээр энэ Татварын багц хуулийн шинэчлэл, НӨАТ, энэ НӨАТ-ын гажуудлын тогтолцоо байна. Аж ахуйн нэгжүүд дээрээ ч гэсэн борлуулалтын татвар шиг болсон. Иргэддээ ч гэсэн дарамт болсон энэ татварын тогтолцоог хурдан шинэчилж, иргэдийнхээ амьдралд ээлтэй, мөн том утгаараа эдийн засгийнхаа бодлогыг чиглүүлэх бодлогууд дээрээ анхаарч ажиллах байх гэж найдаж байна.

Тэгээд амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батын Батбаатар гишүүн үг хэлнэ.

**Б.Батбаатар:** Монголчууд бэлгэдлийн ард түмэн. Аливаа зүйлийг эхэлж байгаа үйл хэрэг дээр дандаа ерөөл айлтгаж байдаг.

Монгол Улсын Засгийн газар аль нь ч бай, үе үеийн Засгийн газрууд тогтвортой, зөв ажиллаж байвал тэр нь хамгийн зөв.

Одоо дурдахад 126 гишүүнтэй Улсын Их Хуралд 4 нам, нэг эвсэл бүхий 5 улс төрийн хүчинтэй энэ парламентад Засгийн газрын тэргүүнийг Ерөнхий сайдыг санал болгох эрх ганцхан намд байгаа. Монгол Ардын намд.

Үндсэн хуулиараа бусад намуудад тийм эрх, санаачилга, боломж байхгүй.

Тийм болохоор Ерөнхий сайдад нэр дэвшигчийг би тэр энэ гэдэг хүнийхээ хувьд хэлэхээсээ илүү эрх бүхий субъект буюу Монгол Ардын нам өөрийнхөө дотоод шалгуур, улс төрийнхөө шийдвэрээ гаргаж Улсын Их Хуралд Ерөнхийлөгчөөр дамжуулан оруулж ирж байна гэж ингэж үзэж байгаа.

Ер нь ардчилсан улс орны ардчилсан байх, үгүйг Үндсэн хуулиасаа гадна их олон процессын асуудлууд нь шийдэж өгч байдаг.

Эрх мэдэл нэгээс нөгөөд шилжихдээ хурдан шуурхай, нээлттэй, ил тод тайван замаар шилжиж, сонгууль нь ч гэсэн тэгж болдог. Ийм байвал тэр улсын ардчилал хангагдаж байдаг ийм өнцөгтэй. Энэ асуудал дээр ямар нэг байдлаар цаг хугацаа алдах, ямар нэг байдлаар хөшигний цаана орох нь тухайн улсад ардчилал нь мөхөж, засаглал, улс төр, эдийн засгийн хямрал эхэлж, эцэст нь иргэд нь хохирдог.

Өнөөдөр бид нарын яриад байдаг монгол төгрөгийн үнэ ханш, валютын өөрчлөлт, эдийн засгийн нөхцөл байдал, дээрээс нь тэр III цахилгаан станцад нэг турбин дэлбэрч байна гэдэг чинь цаг үе нь тохиолдол нь таарсан боловч яаралтай шийдэх ёстой газар улс төрийн шийдвэр гаргадаг Улсын Их Хурал, Засгийн газар, энэ түвшинд л байдаг.

Тийм болохоор ер нь эрх мэдэлд шилжих процессыг хурдан явуулахад парламентад суудалтай улс төрийн намууд болон Улсын Их Хурлын гишүүд дэмжсэн, дэмжээгүй нь хамаагүй үүнийг гацаахгүй хурдан явуулах тал дээр нь анхаарах нь бас ардчилсан Монгол Улсад хэрэгтэй юм гэж үзэж байна.

Ерөнхий сайд томилогдоход “Үндэсний эв нэгдлийн”, “Шинэчлэлийн”, “Хөгжлийн” гээд янз бүрийн байдлаар албан бусаар Засгийн газраа нэршүүлж нэрлэж хэлж байдаг.

Энэ нь өөрөө юуг хэлж байна вэ гэхээр энэ Засгийн газар энэ эрх мэдлийг гүйцэтгэж байх хугацаандаа юуг гол бодлого болгох юм бэ гэдгээ тодорхойлж байгаа агуулгын улс төрийн илэрхийлэл.

Одоо бүрдэх Засгийн газар нэг нэршлийг анхаарч үзээсэй гэж хүсэж байгаа юм.

Ер нь эдийн засаг хөгжүүлэх, шударга ёс, энэ хууль эрх зүй, авлигалын эсрэг тэмцэл, инфляц гээд олон зүйлийг ярьж байгаа боловч энэ бүхэн очоод нэг л газар зангидагдана.

Монголын 3.5 сая хүн бүгдээрээ сайхан амьдрах ёстой, аз жаргалтай байх ёстой, санхүүгийн эрх чөлөөтэй байх ёстой.

Энэ 3.5 сая хүнийг ядууралгүй байлгахын төлөө ядуурлын эсрэг Засгийн газар байгаасай гэж хүсэж байгаа юм. Энэ Монгол Улс өвөг дээдсээс өвлөгдөж ирсэн баялаг дээр нь өнөөдрийн Монгол Улс оршиж байгаа.

Тийм болохоор энэ байгаль экологи энэ чигээрээ өвлөгдөж үлдэх ёстой гэдэг дээр зогсдог ийм Засгийн газар бүрдээсэй гэж хүсэж байгаа. Бодлогын гол үндэс нь, нэршлийн гол агуулга нь, үнэт зүйл зарчим нь түүн дээр байгаасай гэж хүсэж байна. Ингээд амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Номтойбаяр гишүүн үг хэлье.

**Н.Номтойбаяр:** Нэр дэвшигчийг дэмжиж байгаа.

Тэгэхдээ та Ганзоригийн Тэмүүлэнтэй Бага хурал дээр өрсөлдөхөд Цагаан ордонд орж саналаа өгөхгүй ч гэсэн зайнаас сэтгэлээрээ Г.Тэмүүлэнг дэмжээд явж байснаа хэлье.

Түрүүний асуусан асуултад Төрийн байгуулалтын байнгын хороон дээр нэг буруу ойлгогдохоор мэдээлэл бас явах шиг боллоо.

Ажил хэргийн хуваарь Г.Занданшатар даргатай сарын өмнө уулзаж байснаас сая л энд гар барьж мэнд мэдлээ.

Ямарваа нэгэн байдлаар, түрүүн Э.Болормаа гишүүн ч гэсэн бас асуугаад байна. Одоо хамтарсан засаг байгуулах урилга өгөх эсэх асуудал ердөөсөө яригдаагүй. Тэртээ тэргүй улс төрийн хувьд сөрөг хүчний манлайлал ч би ажиллаж дадлагажсан, засгийн эрх барих ажил ч дадлагажсан. Ямар ч байр суурин дээр явна. Ямар ч тохиолдолд албан тушаал гуйж энд тэнд даргын үүд сахиж амьдралдаа ч үзээгүй, цаашдаа ч үзэх ч үгүй.

Тэгэхээр энэ дээр нэг тийм хар буруу хардалтуудыг битгий өдөөж явуулаарай.

Хоёрт нь юу вэ гэхээр, яах аргагүй энэ цаг үед нийгэм, эдийн засгийн энэ нэг угжирсан энэ нэг коммунизм, социализмаас үүдэлтэй өнөөдрийг хүртэл амьд оршин тогтноод байгаа системийн өөрчлөлтийг ёстой ханцуй шамлаад хийх цаг нь болсон.

Тэгээд өнгөрсөн Засгийн газар хэд хэдэн ажлыг эхлэлийг нь тавьсан. Яах аргагүй л энэ төрийн өмчийг бид 50 гэж тоо яримгүй байгаа юм.

►Эдийн засгийн аюулгүй байдлын чиг баримжаатайг нь тодорхой хэм хэмжээнд авч үлдээд, бусдыг нь бүгдийг нь хувьчлах л хэрэгтэй.

►Төрийн алба, бизнесийн чиг баримжаатайг нь хувьд нь шилжүүлэх л хэрэгтэй.

Түүнээс биш “ЦОМХОТГОЛ” гэдэг үг байж болохгүй. Яах аргагүй энэ төрийн зохицуулалттай хөдөлмөрийн зах зээлээс хувийн хэвшлийн зохицуулалттай зах зээл рүү шилжилт хөдөлгөөнийг бид маш бодлогоор хийх хэрэгтэй.

►Татвар буулгаж, татвар төлөлтийн бааз суурийг бид тэлэх хэрэгтэй.

Нийгмийн даатгалын шинэчлэлийн хууль сая Засгийн газар өнгөрсөн долоо хоногт байна уу, Засгаараа хуралдаж Их Хуралд өргөн барихад бэлэн болсон байна лээ. Энэ заавал хэрэгжих хэрэгтэй.

►Тэгээд ялангуяа эдийн засгийн хувьд төрийн өмчит компаниуд 113-аар тоологддог. Үүнийг эрс шийдэмгий өөрчлөлтийг зайлшгүй л хийх хэрэгтэй.

Тэгээд үүгээр би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр ирэх сонгуулиудад улс төрийн оноо алдах вий, сонгогчдоо алдах вий гэдэг сонгуулийн нүдээр огт харж болохгүй.

Тэгээд сүүлд нэг зүйлийг хэлэхэд би яагаад итгэл төрөхгүй байна вэ гэхээр ердөөсөө 100 хувь үнэнч шударгаар Их Хурал, Засгийн газар явж ирээгүй нь үнэн. Гэхдээ ямартай ч нэг чигч, журамт зан зарчмыг барьсаар ирсэн.

Өнөө цагийн улс төрд энэ байхгүй болсон. Энд л ерөөсөө нэг тийм итгэл төрөхгүй байна гээд л удаа дараа хэлээд байгаа юм.

Тэгээд Засгийн газраа. Та бас хэлж байна. “Муур ямар өнгөтэй байх нь хамаагүй хулгана л барьж чадах хэрэгтэй” гээд. Гэхдээ болж өгвөл хар муураар битгий Засгийн газраа бүрдүүлээрэй. Болж л өгвөл нэг цагаан мууруудаар Засгийн газраа бүрдүүлээрэй гэж танаас хүсье. Хар муур бол тэгээд л юу болдгийг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ.

Тэгээд амжилт хүсье танд.

**Ж.Бат-Эрдэнэ:** Э.Болормаа гишүүн үг хэлнэ.

**Э.Болормаа:** Ингээд нэр дэвшигчдээ хандаад онцгойлон нэг саналыг хэлэх гэсэн юм.

Төрийн байгуулалтын байнгын хороон дээр миний хувьд олон удаа онцгойлон хэлдэг яахын аргагүй төрийн албаны шинэчлэл.

Тэгээд энэ асуудлыг та сая ямархуу байдлаар хөндөх дээр саналуудаа хэллээ.

Тэгээд төрийн албаны шинэчлэл гэдэг бол ер нь Засгийн газрын бүрэлдэхүүнийхээ хандлагаас ч гэсэн эхэлнэ. Туршлагатай хүний хувьд та асуудлууд ямар байгааг бараг хүнээр хэлүүлэлтгүй мэдэж байгаа байх.

Тийм учир цаг алдалгүй яг энэ төрийн албаны шинэчлэлийн асуудлыг оруулж ирээсэй гэж хүсмээр байна. Ер нь энэ 126 гишүүнтэй парламент нам харгалзахгүй төрийн албанд шинэчлэл хэрэгтэй гэдэг дээр санал нэгддэг байх гэж бодож байна.

Тэгэхээр парламентын зүгээс энэ асуудал дээр маш хурдтай дэмжээд явах болов уу. Энэ бол яг ажлын бүтээмж. Цаашдаа Засгийн газрын амжилт гэдэг ерөөсөө л ажлын үр дүн.

Тэгэхээр тэр үр дүнг бий болгох систем нь илүү бүтээмжтэй байх дээр нэн тэргүүнд анхаараасай гэж хүсэж санал хэлье.

Тэгээд амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Алтангэрэл гишүүн үг хэлнэ.

**О.Алтангэрэл:** Г.Занданшатар дарга өөрөө судалгааны ажил эрхэлдэг, энэ чиглэл рүү нэлээн дөртэй хүн.

Тэгэхээр сая манай Ж.Баярмаа гишүүн, С.Зулпхар гишүүн тэгээд энэ нөгөө эрх чөлөөний индекс ярьж байна л даа.

Аль алин индексийг нь бид авах ёстой. Жишээлбэл, Ж.Баярмаа гишүүний ярьж байгаа дурдаж байгаа тэр **V-Dem Index** /VARIETIES OF DEMOCRACY INDEX/ бол тэр Шведийн Гётеборгийн [/Göteborgs universitet/](#) их сургуулиас 2014 оноос хойш эхэлж гаргаж байгаа.

3500 гаруй экспертүүдийн дүгнэлтээр гардаг.

Энэ дээр манай улс 100 буюу нэг бүхэл гэдэг онооноос 0.47 байж байгаад 45 болоод ухраад ингээд 50 хувиас доошоо болоод байгаа.

Нөгөө **Freedom House**-ийн индексээр бид 84 оноотой. Харьцангуй сүүлийн жилүүд тогтвортой гайгүй байгаа.

Тэгэхдээ бид юу гэдэг юм, гайгүй индексийг нь аваад, жоохон тааруухныг нь авахгүй гэдэг байдлаар биш, өөрсдөө дүгнэлт хийх ёстой юм. Хууль зүй, дотоод хэргийн салбарыг удирдаж явж байсны хувьд тэр хоёр дахь индексийнх нь асуудалд бас нэлээн анхаарал хандуулсан юм.

Тийм учраас Улсын Их Хуралд хүний эрхийн багц хууль гээд 12 хууль. Үүнээс 11 нь хэлэлцэхээр болсон.

Мөн Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай, Хэвлэлийн эрх чөлөөний тухай гээд энэ хүний эрхтэй холбоотой хуулиудыг өргөн мэдүүлсэн.

Тэгэхээр Засгийн газрынхаа залгамж чанар, төрийн ажлын бодлогын залгамж чанарыг хадгалж Та чуулганаар дэмжээд томилогдох юм бол энэ Монгол Улстай холбоотой санаа зовоож байгаа энэ индексийн үзүүлэлттэй холбоотой зүйлүүд дээр анхаарал тавьж, Монгол Улс буцаад аль ч индексээрээ ардчилсан байдаг, аль ч индексээрээ хүний эрх, эрх чөлөөний үзүүлэлтээр сайн байдаг энэ тогтолцоо руу хичээж ажиллаарай гэж хүсье.

Нөгөө талаар “**Авлигын төсөөллийн индекс**” /Corruption Perceptions Index, CPI/ байгаа.

Монгол Улс 121 дүгээр байрт байж байгаад, энэ жил буюу өнгөрсөн жилийн оноогоор 114 буюу 7 байр урагшилсан. Оноо хэвдээ байгаа. Бусад улсууд муудсан.

Тэгэхдээ энэ дээр байр урагшилж байгаа учраас “**өрсөлдөөнт**” гэдэг нэг ийм тодотгол, ангиллын нэг давуу тал гарсан шүү. Хэдүүлээ энэ өрсөлдөөнийг үргэлжлүүлээд урагшаагаа энэ индексээ буулгаад явахад өнөөдөр Улсын Их Хурал дээр бас өргөн баригдсан байгаа Нийтийн албан тушаалтны хууль бус

хөрөнгө, орлогыг иргэний журмаар хураах, нөхөн төлүүлэх тухай хууль болон үүнтэй зэрэгцэж явж байгаа Авлигын эсрэг багц хуулийн төслүүд чухал үүрэгтэй.

Мөн хувийн эрх зүйн чиглэлээр хуулийн төслүүд өргөн баригдсан байгаа. Үүнд Төлбөрийн чадваргүйдлийн буюу Дампуурлын тухай хууль. Мөн Арилжааны хууль гээд Европын Холбоо болон олон улсын зүгээс авлигаа бууруулна гэвэл эдгээр хуулиудыг янзал гэдэг л хуулиудын нэг шүү дээ. Жишээлбэл. Энэ хувийн эрх зүйн хуулиуд гээд энэ хувийн эрх зүйг дэмжих. Мөн маш чухал хууль буюу энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг багцаар нь бид хуулийн төслүүд өргөн барьсан байгаа.

Тэгэхээр танд хандаж хэлэх хүсэлт бол энэ индексүүдийг ахиулахын төлөө, Монгол Улс дахь ардчиллын төлөв байдал, хууль ёс, авлигын эсрэг энэ байдлыг тууштай тэмцэхийн төлөө Засгийн газраас нэлээн санаа тавьж боловсруулсан эдгээр хуулийн төслүүдийг дэмжиж батлуулах тал дээр нь хичээж ажиллаарай гэж захъя.

Төгсгөлд нь, Та Улсын Их Хурлын даргаар хоёр удаа ажиллаж байсан. Байдлыг мэднэ. Мөн Засгийн газрын гишүүн ч байсан хүн.

Өнгөрсөн 18 жилийн турш яригдаад ерөөсөө ямар нэг гарц шийдэлгүй байсан стратегийн орд газрууд, энэ дундаа Оюу Толгой, Тавантолгой буюу Ухаахудаг, Асгатын мөнгөний ордтой холбоотойгоор асуудлууд Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсан.

Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр элдвээр гүтгүүлж, муулуулж, дайруулж байсан ч гэсэн энэ дээр ямарваа нэг ахиц гаргаж бид Баялгийн санг арвижуулахын төлөө явсан. Энэ тэмцэл өөрөө хүнд юм байна лээ.

Тэгэхээр үүнээс шантралгүйгээр энэхүү тэмцлийг үргэлжлүүлээрэй гэж захъя. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэг товчхон нэг хэдэн үг хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар даргатай Та бид 8 жил хамт ажилласан. Энэ парламентад сууж, парламентыг сайжруулах, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хянах, үйл үйл ажиллагааг нь сайжруулах тал дээр хамтарч нэлээн ажилласан.

Миний хувьд ажлын байрыг нэмэгдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх, ард иргэдийн амьжиргааг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, аж ахуйн нэгжүүдийг хөл дээр нь босгох, чадавхжуулах гээд нэлээн олон ажлуудыг дандаа хийж ярьж явж байсан. Та маш сайн мэдэж байгаа.

Тэгээд энэ өнцгөөс ажиллаасай гэж би үнэхээр хүсэж байна. Ядууралыг бууруулах хөтөлбөр боловсруулж байгаа.

Тэгэхээр та нэг зүйлийг мэднэ. Энэ танхим дотор ярьж байгаа сайд нар сайд нар болохдоо тухайн салбар дээрээ хийх ажлуудаа ярьж ярьж байгаад тэгээд сайд болсон хойноо арай ондоо юм яриад ингээд цаашаагаа явдаг. Би ч гэсэн парламент дээр хамт байж байхдаа Та санал нэг байсан, шүүмжилдэг байсан.

Парламентын хүрээнд бодлогын асуудлуудыг ярьчхаад, мөрийн хөтөлбөрөөсөө арай ондоо зүйлүүдийг яриад, хийгээд явдаг байсан гэж.

Тэгэхээр хамгийн гол асуудал бол таныг би юу хүсээд байна гэхээр энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, ард иргэдийн орлогыг дээшлүүлэх, ядуурлын бууруулах энэ хөтөлбөрийг цаашаа том хөтөлбөр болж хэрэгжүүлээсэй гэдгийг л хүсэж байна. Өөрөөр хэлбэл ядууралтай тэмцэх энэ бодлогыг бариасай л гэж би хүсэж байгаа шүү. Та үүнийг түрүүний хэлсэн яриандаа гаргалаа.

Тэгээд үүнийг цаашаа хэрэгжүүлээд яваарай гэж хүсэж байна. Ингээд амжилт хүсье. Танд.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/ Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 19 гишүүнээс 16 гишүүн оролцож, 84.2 хувиар санал дэмжигдлээ.

Ж.Баярмаа гишүүнийг дэмжсэнээр протоколд тусгая. Программ нь ажилласангүй.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг ийнхүү дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулна.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 13 цаг 24 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**